



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
ЭРХ ЗҮЙН ТЭНХИМ

Хар Дэл
Амаржаргалын АНАР

**ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН КОРПОРАЦИЙН
ЭРХ ЗҮЙН ОРЧИН: ЗАСАГЛАЛЫН АСУУДАЛ БА
САЙЖРУУЛАХ АРГА ЗАМУУД**



Мэргэжлийн индекс
042101

Эрх зүйн бакалаврын зэрэг
Горилсон Дипломын төсөл

Удирдсан
Батхүлэг /Ph.D./

Улаанбаатар. 2026



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
ЭРХ ЗҮЙН ТЭНХИМ

Хар дэл
Амаржаргалын АНАР

ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН КОРПОРАЦИЙН
ЭРХ ЗҮЙН ОРЧИН: ЗАСАГЛАЛЫН АСУУДАЛ БА
САЙЖРУУЛАХ АРГА ЗАМУУД

В Мэргэжлийн
индекс
D042101

Эрх Зүйн Бакалаврын Зэрэг
Горилсон Дипломын
Төсөл

Удирдагч: С.Батхүлэг /Ph.D/

Шүүмжлэгч: Б.Дэлгэрмаа/MBA/

ГАРЧГИЙН ТОВЬЁГ

МЭДЭГДЭЛ.....	i
ТАЛАРХАЛ.....	ii
ТОВЧ ХУРААНГУЙ.....	iii
ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	iv
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	v
НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР	vi
ОРШИЛ	1
Сэдвийн хамрах хүрээ	1
Сэдвийн судлагдсан байдал	1
Судалгааны ажлын зорилго	4
Судалгааны ажлын зорилт	4
Судалгааны арга зүй	5
Шинжлэх ухаан, практикт оруулах хувь нэмэр	5
1 I БҮЛЭГ. ОНОЛЫН ХЭСЭГ	6
1.1 Даатгалын тухай ерөнхий ойлголт	6
1.2 Хадгаламжийн даатгалын олон улсын түүхэн хөгжил	6
1.3 Хадгаламжийн даатгалын тогтолцоог тайлбарлах онол арга зүй ба үндсэн зарчмууд ⁹	
1.4 Хадгаламжийн даатгалын тогтолцооны суурь зарчим, бүтэц.....	11
1.5 Хямралын үеийн нөөц төлөвлөгөөний тухай ерөнхий ойлголт	16
1.6 Монгол улсын хадгаламжийн даатгалын корпорацийн үүсэл хөгжил	17
2 II. БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	21
2.1 Монгол улсын ХДК-н өнөөгийн байдал.....	21
2.2 “Капитал” банкны дампуурлаас суралцах нь	29
2.3 Хадгаламжийн даатгалын тогтолцооны олон улсын харьцуулалт: Солонгос, Япон улсын жишээн дээр.....	32
2.3.1 Өмнөд Солонгос – KDIC-ийн зохицуулалтын бүтэц	32
2.3.2 Япон улсын хадгаламжийн даатгалын байгууллагыг зохицуулагч хууль, үйл ажиллагааны загвар	37
2.4 Хямралын үеийн нөөц төлөвлөгөө-БНСУ болон Япон улсын жишээн дээр	39
2.4.1 БНСУ.....	39

2.4.2 Япон улс.....	39
2.5 Олон Улсын Хадгаламжийн Даатгалын 16 Зарчим ба Монгол Улсын Хэрэгжилтийн Үнэлгээ	40
ДҮГНЭЛТ.....	54
САНАЛ	57
НОМ ЗҮЙ.....	ix

МЭДЭГДЭЛ

Энэхүү дипломын төсөл нь миний өөрийн бүтээл болохыг миний бие баталж байна.
Мөн энэхүү бүтээл нь СЭЗИС-ийн оюуны өмч болох бөгөөд дипломын төслийг номын
сангаар дамжуулан нийтийн хүртээл болгохыг зөвшөөрч байна.

Нэр: А.Анар

Гарын үсэг:

Огноо: 2026/01/06

ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааны ажлыг хийхэд үнэтэй хувь нэмэр оруулж, чиглүүлж, зөвлөсөн удирдагч багш С.Батхүлэг (LL.M), судалгааны ажилд шүүмж, зөвлөмж өгч туслан дэмжиж байсан Эрх Зүйн Тэнхимийн нийт багш нартаа талархал илэрхийлье.

ТОВЧ ХУРААНГУЙ

Энэхүү дипломын ажил нь Монгол Улсын Хадгаламжийн даатгалын корпорацийн дотоод бүтэц, засаглалын механизм, эрх зүйн орчин зэргийг онол, практикийн үүднээс хадгаламжийн даатгалын тогтолцооны сайн жишгийг бий болгоод буй БНСУ болон Япон улстай харьцуулан судалсан. Түүнчлэн, Олон Улсын Хадгаламж Даатгагчдын Холбооноос гаргасан ХДК-ийн баримтлах суурь 16 зарчмуудыг Монгол улс системдээ нэвтрүүлж чадсан эсэх болоод тус зарчмуудын хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгч, сайжруулах эрх зүйн санал, зөвлөмж боловсруулахад чиглэгдсэн болно.

Мөн “Капитал” банкны дампуурлын жишээг судалж, Монгол Улсад банкны хямралын үед урьдчилан сэргийлэх эрх зүйн механизм дутмаг байгааг нотлон харуулсан.

Судалгааны үр дүнд, Монгол Улсын ХДК нь санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэгтэй хэдий ч эрх зүйн орчин болоод бодлогын хэрэгжилтийн хувьд тодорхой сул талуудтай болохыг тогтоов. Иймд олон улсын жишигт нийцсэн бие даасан, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий даатгалын тогтолцоог бүрдүүлэх, шаардлагатайгаас гадна хуульд “түр гүүр банк”, “хямралын үеийн нөөц төлөвлөгөө”, “өрийн эргэн төлөлтийн эрх” зэрэг заалтуудыг тусгах нь зүйтэй гэж үзлээ.

Түлхүүр үгс : *Хадгаламжийн даатгалын корпорацийн засаглал, Хямралын үеийн нөөц төлөвлөгөө, Хадгаламжийн даатгалын сан*

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 0.1 Судлагдсан байдлын судалгаа.....	1
Хүснэгт 1.1 Хураамжийн төрлүүдийн харьцуулалт	15
Хүснэгт 1.2 Хөгжлийн үе шат	18
Хүснэгт 2.1 Хадгаламжийн даатгаалд хамрагдсан 12 банк	27
Хүснэгт 2.2 БНСУ болон МУ-ын эрх зүйн орчны харьцуулалт.....	32
Хүснэгт 2.3 хүснэгтэд IADI-ийн 16 үндсэн зарчим тус бүрийн Монгол Улсад хангалтын байдлыг дүгнэв	41

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ**Нэршил товчлол****АНУ****БНСУ****ХД****ХДК****ХХДК****ХДТ****ХДС****МБ****МУ****Тайлбар**

Америкийн нэгдсэн улс

Бүгд найрамдах солонгос улс

Хадгаламжийн даатгал

Хадгаламжийн даатгалын корпораци

Холбооны Хадгаламжийн Даатгалын Корпораци

Хадгаламжийн даатгалын тогтолцоо

Хадгаламжийн даатгалын сан

Монгол банк

Монгол улс

НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

Нэршил товчлол

Тайлбар

Хадгаламжийн даатгалын тогтолцоо

Банкны дампуурлын үед хадгаламж эзэмшигчдэд хохирлыг нь тодорхой хязгаарын хүрээнд нөхөн төлөх тогтолцоо.

Хадгаламжийн даатгалын корпораци

Монгол Улсад хадгаламжийн даатгалын тогтолцоог хэрэгжүүлдэг, даатгалын сан бүрдүүлэх, хяналт тавих, нөхөн төлбөр олгох чиг үүрэг бүхий байгууллага.

Нөхөн төлбөр

Банк дампуурсан тохиолдолд хадгаламж эзэмшигчид олгогдох мөнгөн нөхөн олговор.

Даатгалын хураамж

Даатгалд хамрагдаж буй банкнаас ХДК-д төлдөг тогтмол төлбөр. Энэ нь тогтолцооны санхүүжилтийн үндэс болдог.

Түр гүүр банк

Дампуурч буй банкны үйл ажиллагааг богино хугацаанд үргэлжлүүлэх зорилгоор түр хугацаанд байгуулдаг банкны хэлбэр.

Хямралын үеийн нөөц төлөвлөгөө

Санхүүгийн тогтолцооны хямралын үед авах арга хэмжээ, зохицуулалтын дараалал, санхүүжилтийн эх үүсвэрийг урьдчилан тодорхойлсон баримт бичиг.

ОРШИЛ

Сэдвийн хамрах хүрээ

Энэхүү дипломын ажлын хүрээнд Монгол Улсын Хадгаламжийн даатгалын корпорацийн дотоод бүтэц, засаглалын зохион байгуулалт, эрх зүйн орчин, тулгамдаж буй асуудлуудыг онол, практикийн үүднээс судална. Судалгаанд БНСУ, Япон зэрэг улс орны хадгаламжийн даатгалын байгууллагуудын засаглалын бүтэц, эрх зүйн зохицуулалт, зохион байгуулалтын туршлагыг Монгол улсын өнөөгийн нөхцөл байдалтай харьцуулан судлахаас гадна уялдуулан сайжруулах санал, зөвлөмж боловсруулахад чиглэнэ. Судалгаа нь голчлон байгууллагын засаглал, бүтэц, эрх зүйн зохицуулалтын түвшинд төвлөрөх бөгөөд санхүүгийн гүнзгий тоон шинжилгээ, эрсдэлийн загварчлал зэргийг хамрахгүй.

Сэдвийн судлагдсан байдал

Хүснэгт 0.1 Судлагдсан байдлын судалгаа

Судлаачийн нэр	Судалсан он	Судалгааны сэдэв	Судалгааны агуулга
Nicholas Ketcha Jr	(2017)	Хадгаламжийн даатгалын тогтолцооны бүтэц болон анхаарах зүйлс	Дэлхийн олон оронд хадгаламжийн даатгалын тогтолцоо хэрэгжиж байгаа хэдий ч энэхүү өгүүлэл нь ихэвчлэн АНУ дахь ХДТ-ны гол онцлог болон түүний туршлагаас сурсан сургамжууд дээр тулгуурласан.
Олон улсын валютын сан	(2000)	Хадгаламжийн даатгал: Ашгийг хүртэж, эрсдэлээс зайлсхийх нь	Хадгаламжийн даатгалыг бусад төрлийн даатгалтай харьцуулан судалж, бүх төрлийн бараа, үйлчилгээнд баталгаа болон батлан даалт өгдөг шалтгаануудыг судалж, хадгаламж болон банкны онцлог шинж чанаруудыг тодорхойлон яагаад ХД санхүүгийн системд зайлшгүй шаардлагатай болохыг тайлбарлана.

			Мөн улс орнууд ХДТ-г нэвтрүүлдэг шалтгааныг авч үзэж, зөв зохион байгуулагдаагүй тогтолцооноос үүдэх эрсдэлүүдийг судлан, эдгээр эрсдэлээс амжилттай зайлсхийж чадах тогтолцооны онцлог шинжүүдийг тодорхойлсон байна.
IEEE explore	(2018)	Индонезийн Хадгаламжийн Даатгалын Корпораци (IDIC)-ийн Тухай Кейс Судалгаа	Өнөө үеийн дижитал шилжилтийн эринд мэдээлэл нь байгууллагын стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх гол тулгуур багануудын нэг болж байна. Индонезийн ХДК (IDIC) нь төрийн байгууллагын хувьд хадгаламж эзэмшигчдийн хадгаламжийг хамгаалах, санхүүгийн тогтолцооны тогтвортой байдлыг хадгалахад идэвхтэй оролцох үүрэгтэй. Эдгээр үүргүүдийг хэрэгжүүлэхэд бодлого боловсруулах, шийдвэр гаргахад шаардлагатай өгөгдөл, мэдээллийг ашиглах хэрэгцээ гардаг тул ХДК-ийг мэдээллийн сан, өгөгдөл зэрэг дээр тулгуурлан хэрхэн хөгжүүлж болох талаар судалсан.
Дэлхийн банк	(2020)	Монгол Улс: Цогц Дүн Шинжилгээ	Банкны системийг сэргээн босгох, Монгол банкныг бэхжүүлэхийн тулд ХДК-ийг бэхжүүлэх, банкны хадгаламжийн даатгалын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, түүнчлэн үр ашигтай ХДТ-оог боловсронгуй болгох IADI-ийн гол зарчимд нийцүүлэх шаардлагатай гэж үзсэн. МБ нь банкнуудын чанаргүй зээлийн

			багцыг банкнуудаас худалдаж авахад зориулж улсын төсвийн санхүүжилт, менежменттэй, хөрөнгийн удирдлагын компани (АМС) байгуулахаар судалсан.
Б.Рэгзэдмаа	(2021)	Монгол улсын хадгаламжийн даатгалын тогтолцоог хөгжүүлэх арга зам	Монгол Улсын банкны салбарт хэт төвлөрөл бий болж, цөөн тооны хувьцаа эзэмшигчдийн эрх мэдэл давамгайлах болсон нь санхүүгийн хүртээмжийг хязгаарлаж, баялгийн тэгш бус хуваарилалтыг улам бүр нэмэгдүүлж байна. Үүнтэй холбоотойгоор банкны засаглалын ил тод, хариуцлагатай тогтолцоог бүрдүүлэх, салбарын тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг нийт иргэдэд хүртээмжтэй болгох шаардлага бодитойгоор тулгарч байна. Иймээс төрөөс банкны салбарын бүтцийн шинэчлэлийг зорилго болгон “Банкны салбарын шинэчлэлийн хөтөлбөр” болон “Зээлийн хүүг бууруулах стратеги төлөвлөгөө”-г боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн нь ХДТ-оог дараагийн шатанд гарган хөгжүүлэх, цар хүрээг нь тэлэх суурь нөхцөл болж байна гэж үзэн санхүү банкны хөгжлийн талаас хадгаламжийн даатгалын сангийн бүтэц, зохион байгуулалтад шаардлагатай байгаа шинэчлэлийн асуудлуудыг хөндсөн.

О.Лхагважаргал	(2019 он)	Хадгаламжийн даатгалын хураамжийг оновчлох боломж	Хадгаламжийн даатгалын корпорацийн тогтолцоо, үйл ажиллагаа олон улсад хэрхэн явагддаг талаар түүний эрсдэлүүдийг судалсны үндсэн дээрх судалгааны ажлын онол, арга зүйн үндэслэлийг тогтоосон. Монгол улсын арилжааны банкны өнөөгийн байдлыг судалсны үндсэн дээр, эрсдэлийг нь тооцох, түүнд тохирсон хураамжийг тодорхойлж судалгааг нэгтгэж дүгнэсний дараа санал зөвлөмж боловсруулсан байна.
Т.Саранцацрал	(2023)	Хадгаламжийн даатгалын эрх зүйн зохицуулалт	Монгол улсын хадгаламжийн даатгалыг холимог тогтолцоонд шилжүүлэхийн ач холбогдол хураамжийн ялгаатай байдал болон бие даасан хуульдаа тусгавал зохих эрх зүйн асуудлуудыг тодорхойлсон.

Судалгааны ажлын зорилго

Энэхүү дипломын ажлын зорилго нь Монгол Улсын Хадгаламжийн даатгалын корпорацийн дотоод зохион байгуулалт болон засаглалын эрх зүйн зохицуулалт, практик хэрэгжилтэд тулгарч буй асуудлуудыг судлан тодорхойлох, улмаар олон улсын ижил төстэй байгууллагуудын эрх зүйн зохицуулалт, засаглалын бүтэцтэй харьцуулсан шинжилгээ хийх замаар Монгол Улсад тохирсон оновчтой шийдлийг боловсруулахад оршино.

Судалгааны ажлын зорилт

- Монгол Улсын Хадгаламжийн даатгалын корпорацийн дотоод бүтэц, зохион байгуулалт болон засаглалын эрх зүйн орчныг судлах.
- Корпорацийн үйл ажиллагаанд нөлөөлж буй засаглалын тулгамдсан асуудлуудыг тодорхойлон задлан шинжлэх.

- БНСУ, Япон зэрэг улсуудын хадгаламжийн даатгалын байгууллагын засаглалын бүтэц, эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах.
- Олон Улсын Хадгаламж Даатгагчдын Холбоо болон Базелийн Банкны Хяналтын Хороо (BCBS) нарын хамтран гаргасан ХДК-ийн мөрдөх суурь 16 зарчмыг Монгол улс ямар түвшинд хэрэгжүүлж байгаад дүн шинжилгээ хийх
- МХДК-ийн засаглалыг сайжруулах эрх зүйн болоод зохион байгуулалтын зөвлөмж боловсруулах.

Судалгааны арга зүй

- Баримт бичгийн шинжилгээ (Document Analysis)
Олон улсын болон Монгол Улсын холбогдох хууль эрх зүйн акт, дүрэм журам, бодлогын баримт бичгүүдийг судлах.
Олон улсын байгууллагуудын (жишээ нь, Олон Улсын Валютын Сан, Дэлхийн Банк, ОУХДХ гэх мэт) тайлан, судалгааны материалуудыг ашиглах.
- Харьцуулсан судалгаа (Comparative Analysis):
БНСУ, Япон зэрэг орнуудын ХДК-ийн засаглалын бүтэц, эрх зүйн зохицуулалтыг Монгол Улстай харьцуулах.
- Кейс судалгаа (Case Study): Олон улсад амжилттай хэрэгжиж буй ХДК-ийн засаглалын бүтэц, эрх зүйн зохицуулалтын туршлагыг судлах.
- Нэгтгэн дүгнэх
Дээрх судалгааны аргыг ашиглан олж авсан мэдлэгээ нэгтгэн дүгнэх

Шинжлэх ухаан, практикт оруулах хувь нэмэр

Судалгааны үр дүн нь Монгол Улсын Хадгаламжийн даатгалын корпорацийн дотоод бүтэц, засаглалын оновчгүй талуудыг тодорхойлох, олон улсын жишигт нийцүүлэн сайжруулах талаар бодлого боловсруулагчид, хяналт, зохицуулалтын байгууллагад бодитой зөвлөмж, чиглэл өгөхүйц ач холбогдолтой. Мөн тухайн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал, хариуцлагатай засаглалыг төлөвшүүлэхэд дэмжлэг болох боломжтой.

I БҮЛЭГ. ОНОЛЫН ХЭСЭГ

1.1 Даатгалын тухай ерөнхий ойлголт

Даатгал гэдэг нь тодорхой хэмжээний төлбөр (ихэнхдээ урьдчилан тохиролцсон) авч, даатгагч нь ослын улмаас гарч болох алдагдлыг тодорхой хугацаанд нөхөн төлөх, эсвэл даатгуулагчид үйлчилгээ үзүүлэхээр амлах тогтолцоо юм. Энэ нь эрсдэлийг зохицуулах нэг арга хэлбэр юм. Даатгалын гол зорилго нь эдийн засагт хохирол учруулж болзошгүй тодорхой бус аюулыг тодорхой болгон хувиргах явдал юм. (Greene Mark Richard, 2025)

Иймд аливаа хувь хүн болон байгууллагын хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй, гэнэтийн шинжтэй, эрсдэл дагуулсан нөхцөл байдлаас үүдэн үүсэх хохирлыг бууруулах, нөхөн төлөхөд чиглэсэн санхүүгийн удирдлагын үр ашигтай хэрэгсэл нь даатгал юм.

Даатгалын үндсэн зарчим нь тодорхой тооны хувь хүн, байгууллага нэгдэн эрсдэлээс сэргийлэх замаар дундын сан бүрдүүлж, тухайн санд хуримтлагдсан хөрөнгийг хохирол учирсан этгээдэд нөхөн олговор хэлбэрээр олгоход оршино. Уг санд оролцогчдын тоо нэмэгдэхийн хэрээр нэгж даатгуулагчид ногдох зардлын хэмжээ буурахын зэрэгцээ учирсан хохирлыг бүрэн барагдуулах санхүүгийн боломж нэмэгддэг. Иймээс даатгалыг бага хэмжээний зардлаар томоохон санхүүгийн хохирлоос урьдчилан сэргийлэх, эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах, хувь хүн, байгууллагын болон нийгмийн хариуцлагын тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн эрсдэлийн удирдлагын оновчтой шийдэл гэж үзэх боломжтой юм. (Монгол банк, Даатгалын ач холбогдол, 2020)

Гэнэтийн эрсдэл нь аль ч түвшинд, ямар ч үед тохиолдох боломжтой учраас тухайн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг шилжүүлэх, эсвэл хүлээн зөвшөөрөх зэрэг зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага үүсдэг. Эдгээр арга хэмжээгийн дотроос учирч болзошгүй хохирлыг гуравдагч этгээдэд шилжүүлэх хамгийн түгээмэл арга нь даатгалд хамрагдах явдал юм.

1.2 Хадгаламжийн даатгалын олон улсын түүхэн хөгжил

Хадгаламжийн даатгал (цаашид ХД гэх) гэж банк дампуурах тохиолдолд хадгаламж эзэмшигчийн банкинд байршуулсан мөнгийг тодорхой хэмжээнд баталгаажуулж, түүний өр төлбөрийг барагдуулахыг санхүүгийн аюулгүй байдлын

тогтолцооны зүгээс хариуцах баталгаа хэмээн ойлгоно. Энэ нь банк өр төлбөрөө төлж чадахгүй болсон үед хадгаламж эзэмшигчдийг санхүүгийн алдагдалд орохоос хамгаалах зорилгоор олон улс оронд хэрэгжүүлдэг арга хэмжээ юм. (Science Direct, 2014)

Анх 1929 оны аравдугаар сард Нью-Йоркийн хөрөнгийн биржийн уналтаас үүдэн дэлхий нийт санхүүгийн хямралд өртөж, түүний эсрэг чиглэсэн нэгдсэн, оновчтой бодлого хэрэгжүүлж чадаагүйгээс голлох төв болох АНУ-д банк, санхүүгийн тогтолцоо ноцтойгоор доголдсон. Үүний үр дүнд хадгаламж эзэмшигчид мөнгөө олноор нь татан авч, банкнуудын өмнө урт дараалал үүсэх буюу “bank run” хэмээх үзэгдэл бий болсон юм. Энэ үеэр банкнууд олонтоо дампуурч, хадгаламж эзэмшигчид ихээхэн хохирол амссан тул банкны системд итгэх итгэл алдараад байсан ба 1863-1933 оны хооронд АНУ-д 17,000 гаруй банк хаалгаа барьж, хадгаламж эзэмшигчид асар их хохирол амссан. Их хямралын эхний дөрвөн жилд (1929-1933) 8,812 банк дампуурч, хадгаламж эзэмшигчид нийт 5 тэрбум ам.доллар алдсан.

1829 оноос эхлэн АНУ-ын зарим муж улс орон нутгийн хэмжээнд хадгаламжийн даатгалын төлөвлөгөө хэрэгжүүлж эхэлсэн. Гэвч эдгээр төлөвлөгөөнүүд нь амжилттай хэрэгжиж чадаагүй бөгөөд хадгаламж эзэмшигчдийг бүрэн хамгаалах боломжгүй байсан. 1932 онд АНУ-ын банкны систем бүхэлдээ хямралд орж, хадгаламж эзэмшигчдийг хамгаалах арга хэмжээ авах зайлшгүй шаардлага тулгарсан.

Ийм нөхцөлд банкны салбарыг тогтворжуулах, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, мөн олон нийтийн банкинд итгэх итгэлийг сэргээх зорилгоор 1933 онд АНУ банкны системдээ хадгаламжийн даатгалын тогтолцоог нэвтрүүлсэн байна. Улмаар 1935 онд дэлхийд анх удаа хадгаламжийн даатгалын үйл ажиллагааг албан ёсоор хариуцан хэрэгжүүлэх Холбооны Хадгаламжийн Даатгалын Корпораци (FDIC) байгуулагджээ (DICOM, 2019 оны тайлан). Холбооны Хадгаламжийн Даатгалын Корпорацийн (FDIC) мэдээлснээр, 1886–1930 оны хооронд Конгресст нийт 150 хадгаламжийн даатгалтай холбоотой хуулийн төсөл өргөн баригдсан байна (IAN S. McCarthy). Нэг хадгаламж эзэмшигчийн хадгаламжийг анх \$2,500 хүртэл даатгасан бөгөөд энэхүү дээд хэмжээг дараагийн жилүүдэд шат дараатайгаар нэмэгдүүлж улмаар дэлхийн санхүүгийн хямралын үеэр \$250,000 болгон нэмэгдүүлсэн.

Харин дэлхийн бусад улс орнуудад хадгаламжийн даатгалыг нэвтрүүлэх үйл явц харьцангуй удаашралтай байсан. FDIC байгуулагдсанаас хойш 1970-аад оны дунд үе хүртэл ердөө тавхан улс — Норвеги, Баруун Герман, Канад, Финлянд, Япон —ХДТ-г бий болгосон байв. Харин 1980-аад оноос эхлэн Эдийн Засаг Хамтын Ажиллагаа, Хөгжлийн

Байгууллага (OECD)-ын бүх гишүүн орнууд ХД-ын системийг нэвтрүүлсэн ба дэлхийн бусад улс оронд ч түгээмэл ашиглагдах болжээ

Иймд төв банк (цаашид ТБ гэх) болон мөнгөний бодлого хариуцсан байгууллагуудын хувьд хадгаламжийн даатгалын хамгийн чухал зорилго нь санхүүгийн системд итгэл төрүүлэх, улмаар банкны давтамжтай дампуурлаас шалтгаалах гадаад сөрөг үр дагаврыг бууруулах явдал юм. Түүхэн туршлагаас харахад, ХД нь санхүүгийн системийг тогтворжуулахад үр дүнтэй хэрэгсэл болохыг харуулдаг.

ХД-ыг нэвтрүүлсэн олон оронд банк дампуурах тохиолдол, түүний хор уршиг огцом буурсан байдаг. Жишээлбэл, АНУ-д 1933 онд хадгаламж эзэмшигчдийн хүлээсэн хохирол даатгагдсан хадгаламжийн 2.15 хувьд хүрч, нийтдээ 4,000 банк хадгаламж эзэмшигчдэд төлбөр хийхээ зогсоосон нь тухайн үеийн системийн эрсдэлийн ноцтой байдлыг илтгэнэ. (IAN S. McCarthy)

Хадгаламжийн даатгалын олон улсын байгууллага

1) Олон Улсын Хадгаламж Даатгагчдын Холбоо (IADI)

ХДТ олон улсад эрчимтэй нэвтэрч байгаатай уялдан, 2002 оны 5-р сард Олон Улсын Хадгаламж Даатгагчдын Холбоо (IADI) байгуулагдсан. Энэхүү байгууллага нь ХДТ-г илүү үр дүнтэй болгоход чиглэсэн удирдамж гаргах болон олон улсын хамтын ажиллагааг дэмжих зорилготой.

Үндсэн үүрэг: IADI нь ХДТ-ны олон улсын стандарт тогтоогч байгууллага бөгөөд дэлхийн улс орнуудын даатгагч байгууллагуудын мэдлэг, туршлагыг хуваалцах гол форум юм.

Үйл ажиллагаа: 2002 онд байгуулагдсан бөгөөд хадгаламжийн даатгалын үр нөлөөг сайжруулах, бодлого, стандарт боловсруулах, гишүүн орнуудын хэрэгжилтийг хянах, банкны дампуурлын мэдээлэл цуглуулах зэрэг үйл ажиллагаа явуулдаг.

Гишүүнчлэл: Дэлхийн 100 гаруй хадгаламжийн даатгагч байгууллага (цаашид ХДБ гэх)-ыг төлөөлдөг. (Insurers, 2025)

2) Базелийн Банкны Хяналтын Хороо (BCBS)

Үндсэн үүрэг: BCBS нь банкнуудын зохистой хяналтын олон улсын стандарт тогтоогч байгууллага бөгөөд ХДТ-ны үр нөлөөг сайжруулахад чиглэсэн бодлого, стандарт боловсруулдаг.

Хамтын ажиллагаа: IADI-тай хамтран "Хадгаламжийн даатгалын үр нөлөөтэй тогтолцооны үндсэн зарчмууд"-ыг боловсруулсан.

Гишүүнчлэл: 28 орны төв банкнууд болон банкны хяналтын байгууллагуудыг нэгтгэдэг. (Bank for International Settlements ;, 2024)

3) Европын Хадгаламжийн Даатгагчдын Форум (EFDI)

Үндсэн үүрэг: EFDI нь Европын хадгаламжийн даатгалын байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжих, мэдээлэл солилцох, бодлого боловсруулах зорилготой байгууллага юм.

Гишүүнчлэл: Европын 49 орны 68 хадгаламжийн даатгалын болон хөрөнгө оруулагчийн нөхөн төлбөрийн схемийг нэгтгэдэг.

4) Санхүүгийн Тогтвортой Байдлын Зөвлөл (FSB)

Үндсэн үүрэг: FSB нь дэлхийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилготой байгууллага бөгөөд ХДТ-ны үр нөлөөг хянах, үнэлэх, зөвлөмж гаргах үүрэгтэй.

Үйл ажиллагаа: IADI болон BCBS-тай хамтран ХДТ-ны үнэлгээ, зөвлөмж боловсруулдаг. (Financial Stability Board, 2012)

1.3 Хадгаламжийн даатгалын тогтолцоог тайлбарлах онол арга зүй ба үндсэн зарчмууд

ХДТ нь банкны тогтолцооны нэг чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд системийн эрсдэлийг бууруулах, иргэдийн хадгаламжийг хамгаалах, мөнгөний бодлогын хэрэгжилтэд эерэг нөлөө үзүүлэх зэрэг олон чиг үүрэгтэй. Эрдэмтэн судлаачид ХДК-ийн үйл ажиллагаа, бүтэц, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийг дараах онолуудын хүрээнд тайлбарладаг.

“Хадгаламжийн даатгалын үндсэн зорилго нь банкны системийг хадгаламжийн хэт таталт буюу сүйрэл дагуулахуйц мөнгөн гүйлгээнээс хамгаалах явдал юм” хэмээн АНУ улсын ХХДК-ийн Ерөнхийлөгч аргсан Robert E. Barnett тодорхойлсон байдаг. (Douglas W. Diamond & Philip H. Dybvig, 1986)

- Нийтийн ашиг сонирхлын онол (Public Interest Theory)-ын хүрээнд ХД-г нийтийн эрх ашгийн төлөөх хэрэгсэл хэмээн үздэг. Diamond ба Dybvig эрдэмтдийн хөгжүүлсэн алдарт загварт, банкны хадгаламжийн эрэлтэд үндэслэсэн өр нь хөрвөх чадварын эрсдэлийг үүсгэж, энэ нь хадгаламж эзэмшигчдийн итгэлийг алдагдуулах шалтгаан болдог. ХД нь уг эрсдэлийг арилгаж, банк руу дайрах үзэгдлийг зогсоох замаар санхүүгийн тогтвортой байдлыг хангах онцгой хэрэгсэл

болохыг харуулсан байдаг. (Diamond, D.W., & Dybvig, P. H., 1983) Нөгөө талаас эрдэмтэн Calomiris болон Jaremski нар ХД нь хувь хүний түвшинд итгэл төрүүлдэг ч системийн хэмжээнд нэгдсэн эрсдэлийг хэт нэмэгдүүлэх магадлалтай. Нэг банкны дампуурлыг даатгал шингээж болох ч олон банк зэрэг дампуурвал даатгалын сан хүрэлцэхгүй байх, улмаар улсын төсөвт хүнд ачаалал ирэх эрсдэлтэй хэмээн үзсэн байдаг. (Calomiris, C. W., & Jaremski, M., 2019) Жишээ нь: 2008 оны дэлхийн санхүүгийн хямралын үед зарим улс орон бүрэн баталгааны схем (blanket guarantee) хэрэглэхэд хүрсэн нь системийн эрсдэл нэмэгдсэн томоохон жишээ юм.

- Хувийн ашиг сонирхлын онолын хувьд (Private Interest Theory) эрдэмтэн, судлаач Kane нь ХД-ыг “улс төр, хувийн эрх ашигт үйлчилдэг татаасны механизм” хэмээн тодорхойлсон. Тэрээр даатгалын системийг улс төрийн нөлөө бүхий бүлгүүдийн ашиг сонирхолд нийцүүлэн чиглүүлдэг, харин энэ нь нийгмийн нийт эрх ашигт сөргөөр нөлөөлдөг гэж үзсэн. Ардчилсан болон авторитар нийгэмд ХД-ыг улс төрийн зорилтот бүлгүүдийн санхүүжилтийг дэмжих хэрэгсэл болгон ашигласан жишээнүүд олон байдаг. Зарим улс төрийн хүрээлэлтэй банкнуудын эрсдэлтэй үйл ажиллагааг даатгалын сангаар хамгаалж, төсвийн дарамт үүсгэсэн тохиолдлууд ч гарсан байдаг. (Kane, E. J., 1990)
- Ёс суртахууны эрсдэлийн онол (Moral Hazard Theory) Банк хадгаламжийн баталгаатай байснаар, банкнууд эрсдэлтэй хөрөнгө оруулалт хийх, чанаргүй зээл олгох эрсдэлийг өсгөх хандлагатай болдог. Даатгал нь хадгаламж эзэмшигчдийг хамгаалах ч, банкны эрсдэлтэй шийдвэр гаргахад шахалт үзүүлэх хүчин зүйл болох боломжтой. Энэ үзэгдлийг "Ёс суртахууны эрсдэл" (moral hazard) хэмээн нэрлэдэг. Хадгаламж эзэмшигчид хадгаламж нь даатгагдсан үед өөрийн мөнгийг аль ч банкинд итгэлтэйгээр хадгалдаг тул банкны үйл ажиллагаанд хяналт тавих нь багасдаг. Банкнууд ч мөн хариуцлагагүй хөрөнгө оруулалт хийх хандлагатай болж болзошгүй байдаг хэмээн Kane зэрэг эрдэмтэд үзсэн байдаг (Kane, 1990).
- Benston ба Kaufman (1997) нарын судалгаагаар, зохицуулалт сул тохиолдолд ХД нь өөрөө санхүүгийн хямрал үүсгэгч хүчин зүйл болж болдгийг харуулсан байдаг. Иймээс ХДК нь хатуу хяналт, эрсдэлийн үнэлгээний тогтолцоотой байх шаардлагатай. (Benston, G. J & Kaufman, G. G., 1997) Мөн Kane болон Laeven нар нь ХДТ-г оновчгүй загварчлах буюу зохицуулалт сул байх тохиолдолд санхүүгийн хариуцлагагүй байдал, даатгалын сангийн алдагдал үүсэж болдог. Шимтгэлийг алдагдалд нийцүүлэн тооцдоггүй бол их хэмжээний эрсдэлтэй, банкнууд хэт бага

зардлаар хамгаалалт авах нөхцөл үүсдэг. Хяналтгүй орхигдвол банкнууд даатгалд найдсан эрсдэлтэй бодлого баримтлах (зээл олголтын хэт тэлэлт гэх мэт) магадлал өндөр хэмээн үзсэн байдаг. (Demirgüç-Kunt, A., Kane, E. J., & Laeven, L., 2008)

- Итгэмжлэгдсэн хяналтын онол (Delegated Monitoring Theory) Банкны үндсэн үүргийг зээлдэгчдийн талаарх мэдээллийг цуглуулах, хянах буюу “итгэмжлэгдсэн хяналт” гэж тодорхойлсон. ХД нь энэ үүргийг тогтвортой гүйцэтгэхэд тус дэм үзүүлдэг. (Diamond, D.W. , 1984)

1.4 Хадгаламжийн даатгалын тогтолцооны суурь зарчим, бүтэц

Хадгаламжийн даатгалын зорилго

ХД-н үндсэн зорилго нь хадгаламж эзэмшигчдийг, ялангуяа жижиг хадгаламж эзэмшигчдийг банк дампуурсан тохиолдолд мөнгөө алдахаас хамгаалах, олон нийтийн итгэл, санхүүгийн системийн тогтвортой байдлыг дэмжих явдал юм. (IADI, 2009) Өөрөөр хэлбэл, санхүүгийн хямрал тохиолдсон үед их хэмжээний мөнгөн хөрөнгөтэй хадгаламж эзэмшигч нь санхүүгийн мэдээлэлд түргэн шуурхай хүрэх магадлалтай учраас, эрсдэлийг хохирол багатай даван туулдаг. Гэтэл жижиг хэмжээний хадгаламж эзэмшигч нь тухайн нөхцөл байдлыг мэдрэх, хямрал тохиолдоход түүнээс гарах арга замаа тодорхойлж чаддаггүйн улмаас хүлээх эрсдэл нь өндөр байдаг. (DICOM, Deposit Insurance Corporation Of Mongolia, 2025)

Хадгаламжийн даатгалын тогтолцоог үр дүнтэй болгоход туслах зарчмууд

- Макро эдийн засгийн нөхцөл байдал, өөрөөр хэлбэл эдийн засаг, зах зээлийн тогтворгүй байдал нь санхүүгийн байгууллагуудын эрсдэлийг шингээх, удирдах чадвар, хадгаламж эзэмшигчдийн зан төлөвт нөлөөлдөг. Санхүүгийн системийн параметрууд нь хадгаламжийн даатгагчийн үйл ажиллагаа явуулах магадлал, түүний санхүүжилт, төлбөрийн чадварт нөлөөлж болно.
- Зохицуулалт, хяналт нь олон улсын холбогдох стандартад нийцсэн байх ёстой, учир нь хяналт шалгалтын хөндлөнгийн оролцоо, шийдвэр хожимдсон ХДС-д шаардлагагүй дарамт учруулж болзошгүй юм.
- Аж ахуйн нэгжийн дампуурлын тухай хууль, зээлдүүлэгчийн эрх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, шүүхийн тогтолцооны үр дүнтэй байдал зэрэг хууль эрх

зүйн болон шүүхийн тогтолцоо нь хадгаламж даатгагчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд ихээхэн нөлөөлдөг.

- Нягтлан бодох бүртгэл, мэдээллийг ил тод болгох горим нь ил тод байдал, зах зээлийн сахилга батыг нэмэгдүүлж, хадгаламжийн даатгагчид байгууллагын эрсдэлийн талаар цаг тухайд нь зөв шийдвэр гаргах боломжийг олгох ёстой.
- Хадгаламж даатгагч нь үйл ажиллагааны хувьд хараат бус, сайн засаглалтай, ил тод, хариуцлагатай, гаднын нөлөөллөөс хамгаалагдсан байх ёстой. Хараат бус байдал, зохистой засаглал, ил тод байдал, хариуцлагын үндсэн шалгуурыг суурь зарчмууд хангадаг.
- Хадгаламж эзэмшигчдийг хамгаалах, санхүүгийн тогтвортой байдалд хувь нэмрээ оруулахын тулд хадгаламжийн даатгагч болон санхүүгийн аюулгүй байдлын бусад оролцогчдын хооронд үйл ажиллагааны зохицуулалт, мэдээлэл солилцох албан ёсны бөгөөд иж бүрэн тогтолцоо байх ёстой. (Financial Stability Institute, 2022)

Даатгагч байгууллагын мандатын төрлүүд (Pay box, Pay box plus, Loss minimiser, Risk minimiser)

2009 онд IADI нь ХД-ын үндсэн зарчмуудыг боловсруулсан бөгөөд энэ нь Санхүүгийн Тогтвортой Байдлын Форум (FSF)-ын дэргэд 2001 онд байгуулагдсан “Хадгаламжийн Даатгалын Ажлын Хэсэг”-ийн урьдчилсан судалгаанд тулгуурласан. Уг ажлын хэсэг “Үр дүнтэй ХДТ-г боловсруулах удирдамж”-ийг гаргаж, даатгалын системийн загварыг боловсруулахад анхаарах бодлогын асуудлуудыг ерөнхийд нь авч үзсэн байна. FSF-ийн тайланд дурдсанаар, ХДТ-ны үндсэн зорилго нь:

- 1) Улсын санхүүгийн тогтолцооны тогтвортой байдлыг хангахад хувь нэмэр оруулах
- 2) Санхүүгийн мэдлэг, туршлага багатай хадгаламж эзэмшигчдийг банк дампуурах үед хадгаламжаа алдахаас хамгаалах явдал юм.

Ажлын хэсэг нийт 20 гол зөвлөмж бүхий удирдамж боловсруулж, хадгаламжийн даатгалын ил тод, хязгаарлагдмал хамрах хүрээтэй системийг шинээр бий болгох эсвэл шинэчлэх гэж буй улс орнуудад зориулжээ. ХДТ-г хоёр үндсэн шинжээр ангилж болно:

- 1) Мандат (зорилго, чиг үүрэг)
- 2) Санхүүжилтийн механизм

ХДТ-ны бодлогын үндсэн зорилго нь хадгаламж эзэмшигчдийг хамгаалах, санхүүгийн тогтвортой байдалд хувь нэмэр оруулах явдал юм. Эдгээр зорилгыг албан ёсоор тодорхойлж, олон нийтэд нээлттэй мэдээлсэн байх шаардлагатай. ХД-ын байгууллагын

чиг үүргээр нь ерөнхийд нь дараах дөрвөн ангилалд хувааж үздэг (үүнд тэдгээрийн хосолсон хэлбэр ч багтана):

1. “Pay box” буюу төлбөр нөхөн төлбөр олгох чиг үүрэг бүхий байгууллага: Энэхүү систем нь маш хязгаарлагдмал цар хүрээтэй бөгөөд зөвхөн банк дампуурсны дараа хадгаламж эзэмшигчдэд нөхөн төлбөр олгоход чиглэдэг. Ихэнх тохиолдолд уг төрлийн ХДК нь банкныг татан буулгах шийдвэрт оролцдоггүй ба зөвхөн шимтгэл тооцох, төлбөр хийхэд шаардлагатай мэдээллийг хүлээн авах хүрээнд ажилладаг.

Жишээ: Их Британийн Санхүүгийн Үйлчилгээний Нөхөн Олговрын Схем (FSCS) нь ийм төрлийн тогтолцоонд хамаарна.

2. “Pay box plus” буюу нэмэлт чиг үүрэг бүхий байгууллага: Үндсэн нөхөн төлбөрийн чиг үүргээс гадна санхүүгийн дэмжлэг үзүүлэх, тодорхой тохиолдолд банкны өөрчлөн байгуулалтын үйл явцад хязгаарлагдмал оролцоо үзүүлэх бүрэн эрхтэй.
3. “Loss minimiser” буюу нөхөн төлбөр олгох, өөрчлөн байгуулах чиг үүрэг бүхий байгууллага: Даатгагч нь банкны хямралыг шийдвэрлэх олон хувилбарт стратегийн дундаас хамгийн бага зардалтай хувилбарыг сонгон хэрэгжүүлэх бүрэн эрхтэй бөгөөд илүү идэвхтэй оролцоотой ажилладаг. Жишээ: Япон, Испани, Турк
4. “Risk minimiser” чиг үүрэг бүхий байгууллага:

Энэхүү тогтолцоо нь илүү өргөн зорилго, чиг үүрэгтэй бөгөөд:

- Системд шинэ гишүүн элсүүлэх, хасах эрхтэй.
- Эрсдэлийг үнэлэх, удирдах чадвартай.
- Гишүүн банкнуудад хяналт шалгалт хийх боломжтой.
- Дампуурч буй банкинд санхүүгийн дэмжлэг үзүүлж, шийдвэрлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх эрхтэй.
- Зарим тохиолдолд журам тогтоох, зөрчилд хариу арга хэмжээ авах эрх бүхий байгууллага ч байж болно. Жишээ:
 - АНУ-ын FDIC
 - Канадын Хадгаламжийн Даатгалын Корпораци (CDIC)
 - БНСУ

Олон Улсын Валютын Сангийн (IMF) сүүлийн үеийн судалгаагаар 184 гишүүн орны 103 нь хадгаламжийн даатгалын системийг хэрэгжүүлдэг байна. Ихэнх оронд хадгаламжийн баталгаат дээд хэмжээ нь АНУ-ын \$250,000-тай харьцуулахад харьцангуй

бага байдаг. Мөн ихэнх улс оронд хадгаламжийн даатгал зөвхөн хувь хүний нэр дээрх хадгаламжид хамаарах бөгөөд хуулийн этгээд, бусад банкнуудын хадгаламжийг хамардаггүй байна.

Санхүүжилтийн механизмууд (Ex ante vs Ex post)

Хадгаламжийн даатгалын тогтолцоог даатгалын хураамжийг тооцох болон хураах аргаар нь ангилдаг. ХДТ-г ангилах хоёр дахь үндсэн шалгуур нь түүний санхүүжилтийн механизм юм. Зорилго, чиг үүргийн нэгэн адил хадгаламжийн даатгалын тогтолцоо нь үндсэндээ хоёр төрлийн санхүүжилтийн аргыг ашигладаг нь тохиолдлын дараах (ex post) болон урьдчилсан (ex ante) санхүүжилт юм.

Тохиолдлын дараах санхүүжилттэй ХДТ (жишээлбэл, Их Британийн Санхүүгийн Үйлчилгээний Нөхөн Олговрын Схем – FSCS) нь банк дампуурахаас өмнө хуримтлуулсан тусгай даатгалын сан байдаггүй. Харин системийн аль нэг банк дампуурсны дараа ХДБ үлдсэн гишүүн банкнуудад урьдчилан тогтоосон томъёоллын дагуу шимтгэлийн төлбөрийн нэхэмжлэл илгээдэг. Зарим эрдэмтэн судлаачид тохиолдлын дараах санхүүжилт нь зах зээлийн сахилга батыг хадгалахад эерэг нөлөөтэй гэж үздэг. Өөрөөр хэлбэл, нэг банк дампуурахад бусад банкнууд зардал хүлээдэг учраас харилцан хяналт нэмэгддэг. Гэсэн хэдий ч энэхүү арга нь хэд хэдэн бодит бэрхшээлтэй.

Нэгдүгээрт, шимтгэл цуглуулах ба хадгаламж эзэмшигчдэд төлбөр олгоход ихээхэн хугацаа шаардагддаг. Хоёрдугаарт, банкны дампуурал нь санамсаргүйгээр тохиолддоггүй, харин эдийн засгийн мөчлөгийн нөлөөнд орж бөөнөөр гарч ирдэг. Өөрөөр хэлбэл, нэг банк дампуурахад бусад банкнууд ч мөн адил дарамтад орж, даатгалын байгууллагаас ногдуулсан төлбөр нь тэдгээрийг ч бас дампууралд хүргэх эрсдэлтэй байдаг.

Иймд олон судлаач, мэргэжилтнүүд урьдчилан санхүүждэг (ex ante) системийг илүүд үздэг. Энэ тохиолдолд ХДС-г урт хугацаанд тогтмол шимтгэлээр бүрдүүлж, хуримтлагдсан хөрөнгийг төв банкны бонд гэх мэт эрсдэл багатай, өндөр хөрвөх чадвартай хөрөнгөд байршуулдаг. Банк бүр энэхүү санд тогтмол шимтгэл төлөх ба энэ нь айл өрх, тээврийн хэрэгслийн даатгалын компанид төлдөг шимтгэлтэй ижил төстэй зарчмаар явагдана. Ингэснээр банкны дампуурлын зардлыг эдийн засгийн мөчлөг даяар жигд хуваарилах боломж бүрдэнэ.

Зарим орон ex ante ба ex post хослуулсан загвар ашигладаг. Жишээлбэл: Суурь санг урьдчилан бүрдүүлнэ, гэхдээ сан хүрэлцэхгүй тохиолдолд ex post нөхөн хураамж авах боломжтой.

Даатгалын хураамжийн тооцооллын төрлүүд

ХДТ-ны үр дүнтэй байдлыг тодорхойлох гол шалгууруудын нэг нь хураамжийн тооцоолол, суурь үзүүлэлтүүд юм. Даатгагч байгууллага нь банкны үйл ажиллагааны цар хүрээ, эрсдэл, зах зээлийн орчинд үндэслэн хураамж тооцохдоо дараах 3 үндсэн аргачлалуудыг ашигладаг.

1) Ижил хувь хэмжээтэй хураамж (Flat-rate premium)

Энэ тооцооллын арга нь бүх банкны хувьд ижил хувь хэмжээтэй шимтгэл тогтоож, тэдгээрээс нэгэн жигд байдлаар шимтгэл хураах аргачлал юм.

2) Эрсдэлд суурилсан хураамж (Risk-based premium)

Энэхүү загвар нь банкны санхүүгийн нөхцөл байдал, активын чанар, зах зээлийн эрсдэл зэрэг хүчин зүйлс дээр үндэслэн өөр хувь хэмжээтэй хураамж тооцдог. Эрсдэл өндөртэй банк илүү их шимтгэл төлнө.

Хөрөнгөд суурилсан хураамж (Asset-based or coverage-based premium)

3) Энэ аргачлалд банкны нийт актив эсвэл даатгагдсан хадгаламжийн хэмжээнд үндэслэн хураамж тооцдог. Ерөнхийдөө, илүү их хөрөнгөтэй банк илүү өндөр хураамж төлдөг.

Хүснэгт 1.1 Хураамжийн төрлүүдийн харьцуулалт

ТӨРӨЛ	СУУРЬ	ДАВУУ ТАЛ	СУЛ ТАЛ	ЖИШЭЭ УЛС
FLAT-RATE	Ижил хувь	Тооцоолол хялбар, хэрэгжүүлэхэд хүндрэл багатай	Банкнуудын эрсдэлийн ялгаа тусгагдахгүй, шударга бус байдал үүсэх боломжтой	Монгол улс Япон (хуучин)
RISK-BASED	Эрсдэлд суурилсан	Зах зээлийн сахилга бат үүсгэнэ, банкнуудыг хариуцлагатай байх урамшуулал бий болгодог	Санхүүгийн болон зохицуулалтын нарийн мэдээлэл шаарддаг, үнэлгээний систем төвөгтэй.	АНУ Герман БНСУ

ASSET-BASED	Хөрөнгөд	Хялбар, ил тод,	Эрсдэлийн ялгаа	Финланд,
	суурилсан	автоматжуулахад	тусгагдахгүй,	Чех
	хураамж	тохиромжтой	банкны бүтэц харгалзахгүй	

Эх сурвалж : (Demirgüç-Kunt, A., Kane, E. J., & Laeven, L., 2008)

1.5 Хямралын үеийн нөөц төлөвлөгөөний тухай ерөнхий ойлголт

ХДБ болон санхүүгийн аюулгүй байдлын сүлжээний бусад оролцогчид нь бие даан болон хамтын ажиллагааны хүрээнд хямралын нөхцөл байдал, санхүүгийн хямралын үед баримтлах бодлого, журам, үйл ажиллагааг тодорхойлон боловсруулдаг. Нөөц төлөвлөгөө нь тухайн байгууллагын үйл ажиллагааны болон санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах арга хэмжээг урьдчилан тодорхойлоход тусалдаг.

ХДК нь банкны дампуурал болон бусад эрсдэлд бэлэн байж үр дүнтэй хариу арга хэмжээ авах чадвартай байхын тулд болзошгүй нөхцөл байдалд урьдчилан бэлтгэсэн хямралын үеийн нөөц төлөвлөгөөтэй байх шаардлагатай. Системийн хэмжээнд учирч болох хямралд бэлэн байж, менежментийн бодлогыг боловсруулах нь санхүүгийн системд оролцогчдын хамтын үүрэг байдаг. ХДК нь системийн хэмжээнд хямралд бэлэн байх, удирдахтай холбоотой санхүүгийн аюулгүй байдлын сүлжээнд оролцогчдыг хамарсан байнгын харилцаа холбоо, зохицуулалтын аливаа байгууллагын тогтолцооны гишүүн байх ёстой.

Хэдийгээр ХДТ нь хязгаарлагдмал тооны банкны дампуурлыг шийдвэрлэх чадвартай боловч “системийн хэмжээний банкны хямралыг бие даан шийдвэрлэх боломжгүй” гэж 2001 оны Санхүүгийн Тогтвортой Байдлын Форум (FSF) онцолсон байдаг. Хэрэв системийн хямрал даатгалын байгууллагын нөөц хөрөнгийг шавхахуйц хэмжээний эрсдэл авчирвал тэр нь олон жилийн турш хуримтлуулсан их хэмжээний хөрөнгөтэй байсан ч гэлээ боломжит бүх шаардлагыг хангах чадвар хүрэлцэхгүй байж болзошгүй.

Ийм нөхцөлд засгийн газар илүү хүчтэй баталгаа гаргах шаардлага үүсдэг. Үүнийг “нийтлэг баталгаа” (blanket guarantee) гэж нэрлэдэг ба энэ нь банкны хадгаламж болон зарим тохиолдолд бусад үүргийг (жишээлбэл, банк хоорондын зээлийн өр) засгийн газрын зүгээс бүрэн хамгаалж буй баталгаа юм. Ийм баталгааг ноцтой системийн хямралын үед олгодог бөгөөд дэлхийн олон улсад янз бүрийн банкны хямралын үед хэрэглэж байсан.

Жишээлбэл:

- Швед (1990–1991 он)
- Япон (1990-ээд оны банкны хямрал)
- Азийн санхүүгийн хямралын үеэр (1997–1998 он)
- Дэлхийн санхүүгийн хямралын үед олон улс орон энэ арга хэмжээг хэрэглэсэн.
Тухайлбал: Ирланд, Их Британи, Австрали, Сингапур, Арабын Нэгдсэн Эмират улс

Эдгээр нийтлэг баталгааг зөвхөн засгийн газар олгох боломжтой. Учир нь засгийн газар нь баталгааг санхүүжүүлэхэд шаардагдах, хөрөнгө босгох эрх мэдлийг цор ганц эзэмшигч байдаг. Гэвч зарим улсын хувьд засгийн газар нийтлэг баталгаа гаргаснаар өөрөө дампуурах эрсдэлтэй байж болзошгүй нөхцөл үүсдэг. Тиймээс аливаа боломжит баталгааг гаргах этгээд нь ийм баталгааг гаргахдаа хууль эрх зүйн чадамжтайгаас гадна, санхүүгийн хувьд бодитой байх ёстой.

- 1) Хадгаламжийн даатгагч нь банкны дампуурал болон бусад үйл явдлын эрсдэл, бодит байдалд үр дүнтэй хариу арга хэмжээ авах чадвартай байхын тулд эрсдэлийн үр дүнтэй төлөвлөлт, хямралын менежментийн бодлого, журмыг мөрддөг.
- 2) Эрсдэлийн төлөвлөлт, хямралын менежментийн төлөвлөгөөгөө боловсруулж, тогтмол туршдаг.
- 3) Системийн хэмжээнд хямралд бэлэн байх, удирдахтай холбоотой аюулгүй байдлын сүлжээнд оролцогчдыг хамарсан байнгын харилцаа холбоо, зохицуулалтын аливаа байгууллагын тогтолцооны гишүүн юм.
- 4) Менежменттэй холбоотой гэнэтийн тохиолдлын төлөвлөлт, загварчлалын бэлтгэлд тогтмол оролцдог.
- 5) Хямралын өмнөх болон дараах үеийн менежментийн харилцааны төлөвлөгөө боловсруулахад аюулгүй байдлын сүлжээний бүх оролцогчдыг хамруулж, олон нийтийн мэдлэг, мэдээлэл, харилцаа холбоог иж бүрэн, тууштай хангахад оролцдог.

1.6 Монгол улсын хадгаламжийн даатгалын корпорацийн үүсэл хөгжил

Монгол Улсын санхүүгийн зах зээл, тэр дундаа банкны тогтолцооны хөгжлийг дагаад хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, банкны салбарын тогтвортой байдлыг хангах шаардлага нэмэгдэж ирсэн. Үүний үр дүнд Монгол Улсад албан ёсны хадгаламжийн даатгалын тогтолцоог бий болгох анхны алхмууд хийгдсэн.

МУ зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэн 1990-ээд оны эхэн үед банкны салбар дорвитой өөрчлөлтөд орсон ч тухайн үед хадгаламж эзэмшигчдийн мөнгийг хамгаалах систем бүрдээгүй байв.

1990–2000 оны хооронд Монголын банкны салбарт хэд хэдэн томоохон дампуурал гарч, хадгаламж эзэмшигчдийн итгэлд сөргөөр нөлөөлсөн. Үүний тод жишээ нь 1994–1999 оны банкны хямрал бөгөөд тухайн үед хэд хэдэн банк дампуурч, хадгаламж эзэмшигчид их хэмжээний хохирол амссан. Энэхүү хямрал, алдагдлуудын дараагаар олон улсын туршлагыг судлан, Монгол Улсад ХДТ бий болгох шаардлагыг онцгойлон авч үзэх болсон юм.

2013 оны 1-р сарын 10-нд УИХ-аас “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль” (цаашид БДМХтХ гэх) баталж, хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү хууль нь иргэн, хуулийн этгээдийн мөнгөн хадгаламжийг хамгаалах, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилготой бөгөөд банкин дахь мөнгөн хадгаламжийн албан журмын даатгалын эрх зүйн үндсийг тогтоож, ХДС-ийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулдаг.

Тус хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор төрөөс “Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо” болон албан журмын даатгалын үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэгтэй, ашгийн төлөө бус, төрийн өмчит “Хадгаламжийн даатгалын корпораци”-ийг байгуулсан. Энэ нь хадгаламжийн даатгалын тогтолцоог хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна. МХДТ нь хадгаламж эзэмшигчдийг банкны дампуурлаас хамгаалж, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилготой. Энэ нь олон нийтийн итгэлийг нэмэгдүүлж, банкны тогтолцооны аюулгүй байдлыг хангах чухал механизм юм.

Хүснэгт 1.2 Хөгжлийн үе шат

Үе шат	Тайлбар
2010-2013	Хадгаламжийн даатгалын тогтолцооны талаарх хэлэлцүүлэг, хууль боловсруулалт. Олон улсын туршлагыг судалсан. (АНУ-ын FDIC, Канадын CDIC, БНСУ-ын KDIC гэх мэт.)
2013	Хадгаламжийн Даатгалын тухай хууль батлагдаж, Хадгаламжийн даатгалын корпораци албан ёсоор байгуулагдсан. Үйл ажиллагааны суурь тавигдсан.
2014–2016	Банкнудыг гишүүнчлэлд хамруулж, иргэдэд хадгаламж хамгааллын талаарх мэдээлэл түгээн, нөхөн төлбөрийн журам боловсруулсан.

2017–2020	Олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагаагаа бэхжүүлсэн (IADI-ийн гишүүн болсон). Эрсдэлийн хяналтын чадавхыг сайжруулсан. Эрсдэлд суурилсан хураамжийн системд шилжих бэлтгэл хийсэн.
2020–Одоо	Засаглал, сангийн хангалттай байдлыг үнэлэх ажлуудыг эрчимжүүлсэн. Нөхөн төлбөрийн бэлэн байдлын сургуулилалтууд хийсэн. Даатгалын дээд хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг судалж байгаа.

Эх сурвалж : Хадгаламжийн даатгалын корпораци

Бүлгийн дүгнэлт

ХД нь эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах, хувь хүн, байгууллагын санхүүгийн эрсдэлийг бууруулах чухал механизм болохыг онолын болон практик судалгаанууд харуулж байна. Даатгалын тогтолцооны үндсэн зорилго нь санхүүгийн тогтолцооны итгэлийг хадгалах, банкны дампуурлаас үүдэх системийн эрсдэлийг бууруулахад оршдог бөгөөд түүхэн хөгжлийн туршид АНУ, Чехословак зэрэг улс орнууд анхлан нэвтрүүлж, улмаар дэлхий даяар өргөн тархжээ.

Олон улсын байгууллагууд болох IADI, BCBS, EFDI, FSB зэрэг нь ХДТ-ны стандарт, үр нөлөөг дээшлүүлэх бодлого боловсруулж, хамтын ажиллагааг өргөжүүлсээр байна. Даатгалын тогтолцоог үр дүнтэй хэрэгжүүлэхэд хараат бус ажиллагаа, сайн засаглал, ил тод байдал, хариуцлагын зарчмууд зайлшгүй шаардлагатай болохыг үндэсний болон олон улсын баримт бичгүүд онцолжээ.

ХД-ын системийн онолын тайлбарууд болох нийтийн ашиг сонирхлын онол, хувийн ашиг сонирхлын онол, ёс суртахууны эрсдэлийн онол, итгэмжлэгдсэн хяналтын онол зэрэг нь ХД-ын ач холбогдол төдийгүй түүнтэй холбоотой эрсдэл, хүндрэлүүдийг судлахад чухал ач холбогдолтой юм. Түүнчлэн даатгалын сангийн санхүүжилтийн механизм (ex ante, ex post) болон хураамжийн төрөл (ижил хувь, эрсдэлд суурилсан, хөрөнгөд суурилсан) нь даатгалын тогтолцооны үр ашиг, тогтвортой байдлыг тодорхойлох гол хүчин зүйл болдог байна.

Монгол Улсад хадгаламжийн даатгалын тогтолцоо 2013 онд бүрэлдэж, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангахад чухал суурь тогтолцоо болж хөгжиж байна. Гэсэн хэдий ч даатгалын тогтолцооны засаглал, дотоод бүтцийн үр нөлөөг сайжруулах, олон улсын сайн туршлагыг илүү өргөн хүрээнд нутагшуулах шаардлага байсаар байна. Үүнд эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, нөхөн төлбөрийн хурд, сангийн бэлэн байдлыг сайжруулах, эрсдэлд суурилсан хураамжийн системийг төгөлдөржүүлэх зэрэг асуудал чухалчлагдаж байна.

Иймд дараагийн бүлэгт олон улсын хадгаламжийн даатгалын корпорацийн эрх зүйн зохицуулалт, дотоод бүтцийн зохион байгуулалттай харьцуулан Монгол Улсын хадгаламжийн даатгалын тогтолцоонд зайлшгүй тусгах шаардлагатай бодлогын зөвлөмжүүдийг боловсруулан дэвшүүлэх болно.

II. БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

2.1 Монгол улсын ХДК-н өнөөгийн байдал

Дэлхий даяар санхүүгийн тогтолцооны тогтвортой байдлыг хангахад хадгаламжийн даатгалын байгууллагууд чухал үүрэг гүйцэтгэдэг. Монгол Улс ч мөн адил ХДТ-оог бүрдүүлж, хөгжүүлсэн бөгөөд өнөөдөр ХДК нь банкны салбарын эрсдэлийг бууруулах, хадгаламж эзэмшигчдийн итгэлийг хамгаалах чиглэлд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

Удирдлага, засаглалын бүтэц

Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо- Хадгаламжийн даатгалын корпорацийн удирдах дээд байгууллага нь Үндэсний хороо (цаашид ҮХ гэх) юм. ҮХ нь 7 гишүүний бүрэлдэхүүнтэй.

ҮХ нь улирал тутмын хураамжийн хувь хэмжээг тогтоох, даатгалын нөхөн төлбөр олгох шийдвэр гаргах, хөрөнгө оруулалтын бодлого батлах зэрэг чухал бодлого, шийдвэрүүдийг гаргадаг. Тухайлбал, ҮХ жил бүр даатгалын хураамжийн хувь хэмжээг тогтоож (улирлын хувь 0.125%-иас хэтрэхгүй) мөн шаардлагатай тохиолдолд онцгой нэмэлт хураамж ногдуулах эрхтэй байдаг. Мөн даатгалын сангийн хөрөнгө оруулалтын журам, банкны эрсдэлийн түвшинд суурилсан дифференциал хураамжийн аргачлалыг батлах замаар ХДК-ийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах чиг үүргээ хэрэгжүүлдэг.

ҮХ нь ХДК-ийн нийтлэг үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, гүйцэтгэлд нь хяналт тавих үүрэгтэй. Хуульд зааснаар ҮХ нь корпорацийн дүрэм, стратегийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах; корпорацийн бүтэц, жил жилийн үйл ажиллагааны төсөв, сангийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах; хууль, дүрэм, журмыг боловсруулж батлах; санхүүгийн тайлан болон дотоод аудитын дүнг хэлэлцэх; хадгаламж эзэмшигчдэд нөхөн төлбөр олгох эцсийн шийдвэр гаргах; гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх зэрэг өргөн хүрээтэй бүрэн эрхийг хэрэгжүүлдэг (Монгол банк, Банкны салбарын хууль тогтоомжийн эмхэтгэл, 2019).

Гүйцэтгэх удирдлага (Гүйцэтгэх захирал ба менежментийн баг)

ХДК-ийн өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх удирдлага хариуцан явуулдаг. Гүйцэтгэх захирал нь ҮХ-ны баталсан стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд корпорацийн үйл ажиллагааг зохион байгуулж, удирдлагаар хангана. Өөрөөр хэлбэл, гүйцэтгэх захирал нь ҮХ-ны өмнө хариуцлага хүлээж, тэрхүү хорооноос өгсөн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх үндсэн үүрэгтэй байдаг. Корпорацийн гүйцэтгэх

захирал нь хуулийн дагуу “улсын ахлах байцаагч” эрхтэй бөгөөд МБ-ны Ерөнхийлөгчөөс түүнд болон холбогдох албан тушаалтнуудад банкны үйл ажиллагаанд хяналт тавих улсын байцаагчийн эрх олгодог нь ХДК-д хяналт шалгалтын чиг үүрэг хэрэгжүүлэх боломжийг олгодог юм. Гүйцэтгэх захирлын удирдлага дор корпорацийн хэлтсийн захирлууд, нэгжийн дарга нар буюу менежментийн баг өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэдэг (Монгол банк, Банкны салбарын хууль тогтоомжийн эмхэтгэл, 2019).

Үндэсний хорооны дэргэдэх хороо зөвлөлүүд

ХДК-ийн дүрмийн дагуу Үндэсний хорооны шийдвэр, бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор зарим хороод, зөвлөлүүдийг ажиллуулж болно. Жишээлбэл, ХДК нь дотооддоо аудитын нэгжтэй бөгөөд тус нэгжийн гаргасан тайланг ҮХ хэлэлцэж шаардлагатай шийдвэр гаргадаг. Мөн ҮХ-ны дэргэд Ёс зүйн зөвлөл нь Үндэсний хорооны гишүүд, ХДК-ийн ажилтнуудын ёс зүйн дүрмийг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих чиглэлээр ажилладаг (Монгол банк, Банкны салбарын хууль тогтоомжийн эмхэтгэл, 2019).

Дотоод нэгж, хэлтсүүдийн бүтэц

ХДК нь үйл ажиллагааны чиглэл, үүрэг функцийг тусгаарласан хэд хэдэн хэлтэс, нэгжтэй. Корпорацийн үндсэн бүтэц нь гүйцэтгэх захирлын шууд удирдлага дор дараах хэлтэс, албадаас бүрдэнэ:

- Тамгын газрын хэлтэс- Корпорацийн захиргааны болон дотоод ажлыг удирдан зохион байгуулах нэгж. Тамгын хэлтэс нь байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны уялдаа холбоог хангахын зэрэгцээ ХДК-ийн удирдах дээд байгууллага болох ҮХ-ны үйл ажиллагааны бэлтгэл, зохион байгуулалтыг хангаж ажилладаг (DICOM, Deposit Insurance Corporation Of Mongolia, 2025). Мөн хүний нөөц, санхүүгийн удирдлага, дотоод хяналт зэрэг ерөнхий зохицуулга, дэмжлэгийн функцуудыг гүйцэтгэдэг.
- Хуулийн хэлтэс- Корпорацийн хууль, эрх зүйн асуудал хариуцсан нэгж. Хуулийн хэлтэс нь БДМХДтХ болон холбогдох журам, дүрэм, гэрээний хэрэгжилтэд хууль зүйн дүн шинжилгээ хийх, эрх зүйн зөвлөгөө өгөх үндсэн үүрэгтэй. Мөн банк татан буугдах үед ХДК-ийн эрх, ашиг сонирхлыг хуулийн хүрээнд хамгаалах (нэхэмжлэл гаргах, өмгөөлөл хийх) зэрэг ажлыг зохион байгуулна. (DICOM, Deposit Insurance Corporation Of Mongolia, 2025).
- Хяналт шалгалтын хэлтэс- Банк хадгаламжийн даатгалд хамрагдах үйл ажиллагаанд хяналт тавих, шалгалт хийх чиг үүрэг бүхий нэгж. Хяналт

шалгалтын хэлтэс нь БДМХДтХ болон ХДК-иас батлан гаргасан дүрэм, журам, зааврын хэрэгжилтийг арилжааны банкнууд хангаж буй эсэхэд хяналт тавих үндсэн үүрэгтэй байдаг (DICOM, Deposit Insurance Corporation Of Mongolia, 2025). Тухайлбал, гишүүн банкнууд улирал тутам даатгалын хураамжийг зөв тооцон төлж байгаа эсэх, даатгалын сангийн мэдээллийг үнэн зөв тайлагнаж буй эсэх, даатгалд хамрагдах харилцах, хадгаламжийн дансны бүртгэлийг зөв хөтөлж байгаа эсэхэд энэ хэлтэс хяналт тавина. Мөн шаардлагатай тохиолдолд МБ-тай хамтран хяналт шалгалт хийх болон банкны эрсдэлийн үнэлгээнд шаардлагатай мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх ажлыг гүйцэтгэдэг.

- Эрсдэлийн удирдлагын хэлтэс- ХДК-ийн эрсдэлийн үнэлгээ, санхүүгийн шинжилгээ, сангийн хөрөнгө оруулалт хариуцсан нэгж. Эрсдэлийн удирдлагын хэлтэс нь даатгалд хамрагдсан банкнуудын санхүүгийн байдал, эрсдэлийн түвшинг үнэлж, даатгалын хураамжийн хувь хэмжээг эрсдэлд суурилсан аргаар тооцох ажлыг хариуцна. Тус хэлтэс нь ХДК-ийн Даатгалын сангийн хөрөнгийг “аюулгүй, хөрвөх чадвартай, өгөөжтэй байлгах” зарчмын дагуу улсын бонд зэрэг санхүүгийн хэрэгслүүдэд байршуулах, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх үүрэгтэй (Монгол банк, Банкны салбарын хууль тогтоомжийн эмхэтгэл, 2019). Мөн ХДК-ийн дотоод болон гадаад эрсдэлийн (үйл ажиллагааны, санхүүгийн эрсдэл гэх мэт) удирдлагыг зохицуулж, шаардлагатай тайлан мэдээг хүргүүлдэг.
- Нөхөн төлбөрийн хэлтэс- Банкинд даатгалын тохиолдол үүссэн (банк дампуурсан) нөхцөлд хадгаламж эзэмшигчдэд даатгалын нөхөн төлбөр олгох ажиллагаа болон тухайн банкны бүтэц, өр төлбөрийн зохицуулалтад оролцох чиг үүрэг бүхий нэгж. Энэ хэлтэс нь банк албадан татан буугдсан үед ҮХ-оос гаргасан шийдвэрийн дагуу даатгалын нөхөн төлбөрийг төлөх ажиллагааг хэрэгжүүлдэг. Нөхөн төлбөр, бүтцийн өөрчлөлтийн хэлтэс нь ийнхүү даатгалын төлбөр олгох, шаардлагатай бол банкны хөрөнгийг өөр банк шилжүүлэх, эсвэл төлбөр тооцооны дараалалд ХДК өөрөө нэхэмжлэгчийн хувиар оролцох ажиллагааг зохицуулна. Мөн даатгалын тохиолдол үүссэн үед олон нийтэд мэдээлэх, нөхөн төлбөр олгох явцын мэдээг танилцуулах үүргийг энэ нэгж гүйцэтгэнэ (Монгол банк, Банкны салбарын хууль тогтоомжийн эмхэтгэл, 2019).
- Олон нийт, санхүүгийн боловсролын хэлтэс- Хадгаламж эзэмшигч, олон нийтэд хадгаламжийн даатгалын тухай мэдлэг, мэдээлэл түгээх, санхүүгийн суурь боловсролыг дэмжих чиглэлээр ажиллах нэгж (DICOM, Deposit Insurance

Corporation Of Mongolia, 2025). Тус хэлтэс нь МБ болон бусад санхүүгийн байгууллагуудтай хамтран иргэдэд ХДТ-г ойлгуулах сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулдаг. Жишээлбэл, МБ-ны “Олон нийтийн санхүүгийн боловсролын төв”-тэй хамтран хүүхэд, залуучуудад хуримтлалын ач холбогдлыг таниулах арга хэмжээг зохион байгуулсан байна. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр даатгалын нөхөн төлбөр олгох журам, ХДК-ийн үйл ажиллагааны талаарх мэдээг хүргэх үүрэг ч энэ нэгжид хамаардаг (Монгол банк, Банкны салбарын хууль тогтоомжийн эмхэтгэл, 2019).

- Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс- Олон улсын болон дотоодын байгууллагуудтай хамтын ажиллагаа, харилцааг хариуцах нэгж. ХДК нь олон улсын хадгаламжийн даатгагчдын холбоо (IADI)-ны гишүүн байгууллага бөгөөд Евразийн бүсийн хороо (EARC) зэрэг олон улсын түвшинд идэвхтэй оролцдог. Гадаад харилцааны хэлтэс нь энэ хүрээнд гадаадын ижил төстэй байгууллагуудтай туршлага солилцох, сургалт, семинарт хамруулах, техник туслалцааны төслүүдийг зохицуулах, олон улсын арга хэмжээнд корпорацийн төлөөллийг оролцуулах үүрэгтэй. Тухайлбал, 2022 онд ХДК-ийн гүйцэтгэх захирал С.Баатарсүрэн нь IADI-ийн Евро-Ази бүсийн хорооны даргаар сонгогдсон нь тус байгууллагын гадаад хамтын ажиллагааны чадавх дээшилсний илрэл болсон юм. Мөн энэ хэлтэс нь дотоодод МБ, Сангийн яам, Банкнуудын холбоо зэрэг санхүүгийн тогтолцооны институциудтай мэдээлэл солилцох, хамтарсан ажлын хэсэгт оролцох ажил хийдэг (жишээлбэл, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл болон бусад хамтарсан ажлын хэсэгт ХДК-ийг төлөөлөх). Корпорацийн зүгээс мэдээлснээр Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс нь дээрх үйл ажиллагааг зохион байгуулахын зэрэгцээ байгууллагын нийт стратегид хувь нэмэр оруулж буй нэгж юм (DICOM, Deposit Insurance Corporation Of Mongolia, 2025).
- Мэдээлэл технологийн хэлтэс – ХДК-ийн мэдээллийн систем, техникийн дэд бүтэц, өгөгдлийн санг хариуцах нэгж. Тус хэлтэс нь даатгалын мэдээллийн системийг хөгжүүлж, гишүүн банкнуудаас ирүүлдэг хадгаламж эзэмшигчдийн мэдээллийг аюулгүй хүлээн авах, хадгалах, боловсруулах ажлыг гүйцэтгэнэ. Даатгалын тохиолдол үүсэх үед богино хугацаанд олон тооны хадгаламжийн дансны мэдээлэлд үндэслэн нөхөн төлбөрийн дүнг тооцоолох, баталгаажуулахад Мэдээллийн технологийн хэлтэс чухал үүрэгтэй. Мөн байгууллагын өдөр тутмын

мэдээллийн технологийн хэрэгцээ (дотоод сүлжээ, компьютер техник, кибер аюулгүй байдал гэх мэт)-г хангах үйлчилгээг үзүүлдэг.

Дээрхээс гадна дотоод аудитын нэгж нь корпорацийн үйл ажиллагаанд хяналт тавих бие даасан нэг нэгж юм. Дотоод аудит нь ҮХ шууд тайлагнаж, корпорацийн санхүүгийн тайлан, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийдэг бөгөөд ҮХ түүний тайланг хэлэлцэн шаардлагатай арга хэмжээг авдаг нь эрх зүйн зохицуулалтаар баталгаажсан байдаг (Монгол банк, Банкны салбарын хууль тогтоомжийн эмхэтгэл, 2019).

Хэлтэс, нэгж бүр өөрийн чиг үүргийн хүрээнд ХДК-ийн үндсэн үйл ажиллагаа, банкны хадгаламж эзэмшигчдийн даатгалын хамгаалалтыг хэрэгжүүлэх зорилтыг хангахын төлөө харилцан уялдаатай ажилладаг. Өөрөөр хэлбэл, эрсдэлийн үнэлгээ, хяналт шалгалтын нэгжүүд нь хураамж тооцох, сангийн эрсдэлийг удирдахад анхаарч байхад нөхөн төлбөрийн нэгж нь эрсдэлийн хямралын үед шуурхай ажиллах бэлэн байдлыг хангадаг. Олон нийттэй харилцах зэрэг дэмжлэгийн нэгжүүд нь байгууллагын хүний нөөц, материаллаг болон мэдээллийн нөөцийг тасралтгүй ажиллагаатай байлгах үүрэг гүйцэтгэдэг.

Эрх зүйн зохицуулалтын үндэс

БДМХДтХ-д ХДК-ийн удирдах дээд байгууллага, бүтцийн талаар тусгай бүлэг хэсэгт нарийвчлан тусгасан. Тухайлбал, тус хуулийн 22, 24 дүгээр зүйлд Үндэсний хороо, 25 дугаар зүйлд Гүйцэтгэх захирлын эрх, үүргийг тус тус зааж өгсөн. Мөн уг хуулиар сангийн орлого (эхлэлтийн болон улирлын хураамж, онцгой хураамж г.м) ба зарцуулалтын журам, нөхөн төлбөр олгох нөхцөлийг тодорхойлсон.

ХДК нь энэ хуулийн дагуу өөрийн дүрэм (өргөн утгаараа компанийн үндсэн дүрэм) болон дотоод журам, зааврыг батлан мөрддөг. Хуульд зааснаар корпорацийн дүрэм болон дотоод дүрмүүдийг ҮХ батлах эрхтэй бөгөөд бүх гишүүн банкнуудад үйлчлэх “Хадгаламжийн даатгалын журам”-ыг ч мөн баталж мөрдүүлдэг. Корпорацийн ажилтнуудын ёс зүй, мэргэжлийн стандартын баримт бичиг (2018 онд шинэчлэн баталсан ёс зүйн дүрэм г.м)-ийг ч мөн баталж мөрдөж буй (Монгол банк, Банкны салбарын хууль тогтоомжийн эмхэтгэл, 2019).

Бусад эрх зүйн орчин - ХДК нь Монгол банк болон Санхүүгийн зохицуулах хорооны хамтарсан зохицуулалтын үүргийг хүлээдэг зарим тал бий. Тухайлбал, банк шинээр байгуулагдахад МБ зөвшөөрөл олгох үедээ ХДК-д мэдэгдэх үүрэгтэй бөгөөд шинээр гишүүн банк нэмэгдэх, татан буугдах талаар ХДК шаардлагатай мэдээллийг тухай бүр авч ажиллахаар хуульд заасан байдаг (Монгол өмгөөлөгч, 2014). Мөн банк

татан буулгах буюу банкны эрх хүлээн авагч томилогдсон тохиолдолд МБ хадгаламжийн даатгалын нөхөн төлбөр олгох тухай шийдвэрийг гаргаж, ҮХ энэ шийдвэрийг үндэслэн нөхөн төлбөр олгох ажиллагааг эхлүүлдэг. Түүнчлэн ХДК-ийн улсын байцаагчдын эрхийг Монгол банкны Ерөнхийлөгч олгодог (дээр дурдсан) нь Төв банк болон ХДК-ийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангах нэг хэлбэр юм. ХДК нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд банкнуудаас шаардлагатай мэдээллийг авах, шаардлагатай тохиолдолд газар дээрх шалгалтад оролцох эрхтэй бөгөөд энэ үйл ажиллагааг МБ, СЗХ-той хамтран зохицуулдаг.

ХДК-ийн үйл ажиллагаанд мөн “Банкны тухай” хууль зэрэг санхүүгийн системийн бусад эрх зүйн актууд шууд болон шууд бус байдлаар хамааралтай.

Сүүлийн үеийн өөрчлөлт, хөгжлийн хандлага

Сүүлийн жилүүдэд ХДК-ийн дотоод бүтэц, үйл ажиллагаанд хэд хэдэн шинэчлэл, хөгжил гарсан. 2018 онд БДХДтХ-д орсон нэмэлт, өөрчлөлтөөр корпорацийн засаглал, эрсдэлийн удирдлагын чиглэлд сайжруулалт хийжээ. Тухайлбал, хадгаламжийн даатгалын хураамжийг банкны эрсдэлийн түвшинд үндэслэн ялгавартай тогтоох (дифференциал хураамжийн систем) эрх зүйн боломжийг бүрдүүлж, үүнийг дагаад ХДК дотооддоо эрсдэлийн үнэлгээний чадавхаа бэхжүүлэн, мэдээлэл солилцооны программ хангамжийг сайжруулсан (Монгол банк, Банкны салбарын хууль тогтоомжийн эмхэтгэл, 2019).

2019-2022 оны үед ХДК нь Капитал банкны татан буугдах ажиллагааг зохицуулж, даатгалын нөхөн төлбөрийг олгосноор үйл ажиллагааныхаа хувьд шинэ туршлага хуримтлуулсан. Капитал банкны хэрэг явдлын үеэр ХДК гурван жилийн дотор нийт даатгалд хамрагдах хадгаламж эзэмшигчдийн 88.7%-д нөхөн төлбөрийг олгож дуусган, үлдсэн хугацаанд багахан хувь нь нөхөн төлбөрөө авах эрхээ эдэлсэн байна (DICOM, Deposit Insurance Corporation Of Mongolia, 2025). Энэ үйл явц нь ХДК-ийн нөхөн төлбөр, хэвлэл мэдээллийн харилцаа хариуцсан нэгжүүдийн чадавхыг дээшлүүлэх, банк татан буугдах үеийн ажиллагааны төлөвлөгөөг сайжруулахад түлхэц болж, цаашид стратегидаа “Даатгалын төлбөр олгох бэлэн байдлыг тасралтгүй хангах” зорилтыг тусгах үндэслэл болсон.

Менежментийн өөрчлөлт, хүний нөөцийн хөгжил: 2022 онд ХДК-ийн гүйцэтгэх захирлаар С.Баатарсүрэн (үргэлжлүүлэн үүрэг гүйцэтгэгч статустай) томилогдон ажилласан нь боловсон хүчний шинэчлэл байв (Opendata lab Mongolia, 2022). Мэргэжилтнүүдийг олон улсын түвшинд сургах, чадавхжуулахад ч энэ үед анхаарч, IADI

болон дэлхийн бусад даатгалын байгууллагуудтай хамтран сургалт, семинар зохион байгуулах, ажилтнуудыг туршлага судлуулах зэргээр дотоод хүний нөөцийн хөгжлийг эрчимжүүлсэн байна. Үүний нэг илрэл нь дээр дурдсанчлан ХДК-ийн захирал олон улсын хадгаламжийн даатгагчдын Евро-Ази бүсийг даргалж, бүс нутгийн хэмжээнд манлайлах боломжийг олж авсан явдал юм.

Стратегийн баримт бичгүүд: ХДК нь дунд болон урт хугацааны стратеги төлөвлөгөөг ҮХ-оос батлуулан хэрэгжүүлдэг. Сүүлийн жилүүдийн стратегид хадгаламжийн даатгалын сан (цаашид ХДС гэх)-ийн хүрэлцээг нэмэгдүүлэх, эрсдэлийн менежмент, хөрөнгө оруулалтыг сайжруулах, мэдээлэл технологид суурилсан хурдан нөхөн төлбөрийн систем бүрдүүлэх, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх зэрэг зорилтууд туссан байдаг.

Дүгнэн хэлэхэд, МХДК-ийн дотоод бүтэц нь ҮХ-ны удирдлага дор олон функц, чиг үүрэг бүхий хэлтэс, нэгжүүдээс бүрдэн, харилцан уялдаатай ажиллаж байна.

Хадгаламжийн даатгалын корпорацийн хамрах хүрээ

2025 оны 12-р сарын 31-ний байдлаар МУ-д үйл ажиллагаа явуулж буй 12 арилжааны банк (Хүснэгт 2.1-г үзнэ үү) ХДК-ийн гишүүнчлэлтэйгээр хадгаламжийн даатгалд хамрагдаж байна. (DICOM, Deposit Insurance Corporation Of Mongolia, 2025)

Эдгээр банкнуудын хадгаламж эзэмшигчдийн нийт тоо 7,985,308 (давхардсан тоогоор) бөгөөд даатгалын хамрах хүрээнд орж байгаа хадгаламжийн дээд хэмжээ нь 20 сая төгрөг байна. Мөн 2022 оны жилийн эцсийн тайланд дурдсанаар, Монгол Улсад анхны нео-банк болох М Bank үйл ажиллагаагаа эхлүүлснээр ХДК-ийн гишүүн банкнуудын тоо 12-д хүрсэн байна. ХД-д хамрагдах нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй бүх арилжааны банкнуудад заавал биелүүлэх шаардлага бөгөөд энэ нь хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, банкны салбарын тогтвортой байдлыг хангах зорилготой юм.

Хүснэгт 2.1 Хадгаламжийн даатгаалд хамрагдсан 12 банк

ДУГААР БАНКНЫ НЭР	
1	Голомт банк
2	Худалдаа хөгжлийн банк
3	Хаан банк
4	Капитрон банк

5	Кредит банк
6	Ариг банк
7	Богд банк
8	Үндэсний хөрөнгө оруулалтын банк
9	Төрийн банк
10	Чингис хаан банк
11	Монгол шуудан банк
12	М банк (анхны нео банк)

Эх сурвалж : (DICOM, Deposit Insurance Corporation Of Mongolia, 2025)

Гишүүн байгууллагуудаас авч буй шимтгэлийн төрөл

МХДК нь гишүүн банкнуудаасаа хэд хэдэн төрлийн шимтгэл, хураамж авдаг. Хураамжийн тогтолцоо нь нэг удаагийн эхлэлтийн хураамж болон эрсдэлд суурилсан улирлын хураамжаас бүрддэг бөгөөд шаардлагатай үе онцгой нэмэлт хураамж авахаар БДМХДтХ-даа тусгасан байдаг. ХДК нь тогтмол хувьтай нэгэн жигд шимтгэл биш, эрсдэлд суурилсан шимтгэлийн систем ашигладаг бөгөөд энэ нь банкны эрсдэлийн түвшнээс хамаарч хураамжийн хувь хэмжээг өөрчилдөг.

- **Эхлэлтийн хураамж:**

ХДК-д шинээр бүртгүүлж буй банк бүр өөрийн хувьцааны хөрөнгийн 1%-тай тэнцэх хэмжээний хураамж төлөх ёстой. Энэ хураамжийг банк үүсгэн байгуулагдсанаас хойш 30 хоногийн дотор төлөх ёстой. Энэ хураамж нь сангийн анхны санхүүжилтийг бүрдүүлэх зориулалттай бөгөөд бүх банкинд адилхан хувь хэмжээтэй тооцогддог.

- **Улирал тутмын эрсдэлд суурилсан хураамж:**

Гишүүн банкнууд өөрсдийн даатгагдсан хадгаламжийн дүнгийн тодорхой хувьтай тэнцэх улирал тутмын хураамж төлдөг. Хураамжийн хувь хэмжээ нь эрсдэлийн түвшингээс хамаарч өөр тогтоогддог. Үнэлгээг банкны санхүүгийн үзүүлэлт, хяналтын үнэлгээ, хадгаламжийн хүүгийн түвшин зэрэг шалгуураар хийдэг. Хураамжийн хувь хэмжээ жил бүр шинэчлэгдэж, Үндэсний Хорооноос тогтоодог. Улирал тутмын хураамжийн дээд хязгаар: Нэг улиралд нийт даатгагдсан хадгаламжийн 0.125%-иас хэтрэхгүй (жилд 0.5%-тай тэнцэх).

- **Онцгой хураамж (Special Premium):**

Хэрэв банк дампуурч, хадгаламжийн даатгалын сангийн хөрөнгө хүрэлцэхгүй тохиолдолд, ХДК нь бүх гишүүн банкнаас нэг удаагийн онцгой нэмэлт хураамж авах эрхтэй. Онцгой хураамжийн дээд хэмжээ нь даатгагдсан хадгаламжийн жилд 0.5%-иас хэтрэхгүй. Энэхүү нэмэлт хураамжийг зөвхөн банк дампуурсан онцгой тохиолдолд хэрэглэж болох бөгөөд зөвхөн нөхөн төлбөрт зориулагдана.

Хадгаламжийн даатгалын корпорацийн чиг үүрэг, эрх мэдэл

МХДК нь "Pay Box Plus" төрлийн байгууллага юм. МХДК нь нөхөн төлбөр олгох үүрэгтэйгээс гадна, банк дампуурах үед нөхөн төлбөрөөс илүү зардал багатай хувилбар байвал өөр банктай нэгтгэх, шилжүүлэн авах зэрэгт санхүүгийн туслалцаа үзүүлэх эрхтэй.

- Энэ санхүүгийн туслалцааг өгөхдөө заавал “хамгийн бага зардлын зарчим”-ыг мөрдөх ёстой. Өөрөөр хэлбэл, шууд нөхөн төлбөр хийхээс хямд зардлаар дампуурсан банкны асуудлыг шийдвэрлэх нөхцөлд л оролцох боломжтой.
- Хуульд заасны дагуу уг ажиллагааг Монгол банкны зөвшөөрөлтэйгөөр явуулна.

Иймээс: ХДК нь зөвхөн даатгалын мөнгийг төлдөг байгууллага бус, мөн дампуурсан банкны хадгаламжийг шилжүүлэх, банкны шийдвэрлэлтэд оролцох тодорхой эрх бүхий байгууллага гэж үзнэ. Энэ нь олон улсын ангилалд "Pay Box Plus" хэлбэрт хамаардаг.

2.2 “Капитал” банкны дампуурлаас суралцах нь

Энэ хэсэгт МХДК-ийн одоогийн засаглал, бүтцийн асуудлуудыг практик туршлага (Капитал банкны хэрэг)-ын үндсэн дээр тодорхойлж, БДМХДтХ-ийн зарим зохицуулалтад шүүмжлэлтэй дүгнэлт өгнө. Мөн БНСУ (KDIC), Япон (DICJ) зэрэг улсуудын ХДТ-той харьцуулж, хямралын үеийн нөөц төлөвлөгөөний хэрэгцээ шаардлагын талаар болон МХДК-ийн засаглал, үйл ажиллагааны бие даасан байдал, эрсдэлийн удирдлага, хадгаламж эзэмшигчийн хамгаалалтыг сайжруулах шаардлагатай эсэх талаар судална.

Эдийн засаг дахь нийт эргэлтийн хөрөнгийн 92 хувь нь банкаар дамждаг учраас онцгой анхаарах шаардлагатай байдаг. Монгол банкны Ерөнхийлөгчийн 2019 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн А-96 дугаар тушаалаар Капитал банкныг албадан татан буулгах шийдвэр гаргасан бөгөөд мөн өдөр Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо хуралдан “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасныг үндэслэн татан буугдсан Капитал банкны харилцагч, хадгаламж эзэмшигчдэд олгох даатгалын нөхөн төлбөрийг Хаан банкаар дамжуулан олгохоор шийдвэрлэсэн. Энэхүү тохиолдол нь хадгаламжийн даатгалын систем ажиллах анхны

бодит жишээ болсон юм. Уг банк нь санхүүгийн хүндрэлээ даван туулж чадаагүй, өөрийн хөрөнгийн дутагдалтай байсныг аудит, хяналт шалгалтын дүнгээр илрүүлж, шаардлагатай арга хэмжээ (нэмэлт хөрөнгө оруулалт зэрэг) аваагүй тул албадан хаагдсан байдаг (М.Өнөржаргал, 2019). МХДК-ийн үйл ажиллагааны талаас авч үзвэл, Капитал банкны нийт 256,000 хадгаламж эзэмшигчдийн 99.5% нь буюу бага дүнтэй хадгаламжтай ихэнх иргэд хохиролгүй үлдсэн нь ХД зорилгодоо хүрснийг харуулсан. ҮХ шийдвэр гарган даатгалын нөхөн төлбөрийг 20 сая төгрөг хүртэлх бүх хадгаламжид 100% олгохоор болж, төлбөрийг арилжааны томоохон банкаар дамжуулан хэдхэн долоо хоногийн дотор олгож дуусгасан. Энэ нь олон нийтэд банкны дампуурлын шокийг мэдрэгдэхүйц багасгаж, санхүүгийн тогтвортой байдалд доргилт үүсгээгүй гэж мэдээлсэн. (Б.Бат, 2019).

Гэвч нөгөө талдаа, Капитал банкны кейс нь хэд хэдэн сул тал, бэрхшээлийг ил болгосон. Юуны өмнө, даатгалын хамрах дүн хязгаарлагдмал байсан тул 20 саяас дээших хадгаламжтай харилцагчид (нийт хадгаламжийн ердөө 0.5%-ийг эзэлж байсан ч дүнгээрээ багагүй хэмжээтэй) эцсийн дүндээ актив хөрөнгө борлуулалтын орлогоос хэсэгчилсэн төлбөр авч, тодорхой хэмжээний алдагдал хүлээсэн. Мөн уг банкаар дамжин Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба зэрэг төрийн зарим байгууллагын санхүүжилт байршиж байсан нь олон нийтийн анхаарлыг татсан (эдгээр байгууллагын мөнгийг ЗГ хожим нөхөн төлсөн). Энэ нь даатгалд хамрагдахгүй этгээдийн хөрөнгө (хуульд төрийн байгууллагын хадгаламж даатгалд хамрахгүй гэж заасан) хохирох эрсдэлийг бодитоор харуулсан хэрэг болсон.

Түүнчлэн Капитал банкны үйл ажиллагааг тасалдуулалгүй, харилцагчдыг үймээн самуунд автуулалгүйгээр зохицуулах өөр хэд хэдэн хувилбарууд байсан. Даатгалын сангийн хөрөнгө хүрэлцэж байсан учраас хамгийн шуурхай зам буюу хадгаламж эзэмшигчдэд бэлнээр нөхөн төлөх “paybox” хувилбарыг сонгосон. Гэвч оронд нь өөр нэг банктэй нэгтгэх, эсвэл шинэ түр банк (bridge bank) байгуулах замаар хадгаламж, активыг шилжүүлэн авах зэргээр зардал багатай хариу арга хэмжээ авч болох байсан ч БДМХДтХ-д энэ төрлийн арга хэмжээг тусгаагүй мөн БДМХДтХ-н 3.1.8-т өөр банкинд актив, пассив шилжүүлэхэд санхүүжилт үзүүлж болно гэж ерөнхийлөн заасан байдаг. Тиймээс МХДК-д нөхөн төлбөр олгохоос өөрөөр шийдвэрлэх арга замыг хуулийн хүрээнд боловсронгуй болгоогүйгээс зөвхөн нөхөн төлбөр олгох замаар л хадгаламжийн даатгалын системийг хэрэгжүүлж байна.

Цаашид системийн нөлөө бүхий банкинд санхүүгийн асуудал үүсэхэд шууд нөхөн төлбөр олгохоос илүү, үр өгөөжтэй шийдлүүдийг ашиглах хэрэгцээ шаардлагатай.

Мөн тус банкны удирдлагын зүгээс чанаргүй зээл олгох, хөрөнгийн зохисгүй удирдлага зэрэг ноцтой зөрчлүүдийг үйлдэж, улмаар банк төлбөрийн чадваргүй байдалд хүрсэн байдаг.

Үүнээс гадна, олон улсын аудитын байгууллагын хяналт шалгалтаар банкны хөрөнгийн дутагдал тодорхойлогдож, Олон Улсын Валютын Сан (ОУВС)-аас ч Монгол банкинд удаа дараа анхааруулга хүргүүлж байсан. Гэсэн хэдий ч МБ Капитал банкинд зөвхөн хөрөнгийн хүрэлцээг нэмэгдүүлэх шаардлага тавих түвшинд арга хэмжээ авч, илүү үр нөлөө бүхий, дорвитой хяналт, зохицуулалт хэрэгжүүлээгүй нь банкны хүндрэл гүнзгийрэхэд нөлөөлсөн гэж үзэх үндэслэлтэй.

Нөгөөтээгүүр, МХДК нь БДМХДтХ-ийн 21.1.7 дахь заалтаар олгогдсон банкинд хяналт шалгалт хийх бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд 21.1.3-т заасан шаардлага тавигдах ба уг заалтад хадгаламжийн даатгалын үйл ажиллагаатай холбоотой, эсхүл даатгалын тохиолдлын магадлалыг үнэлэхэд шаардлагатай гэж үзвэл банкинд хяналт шалгалт хийлгэх хүсэлтийг Монгол банкинд тавих хэмээн заасан байдаг ба даатгалын тохиолдлын магадлал үүссэн гэдгийг хэрхэн тодорхойлох нь тодорхой бус улмаар хяналт шалгалт хийх эрхээ хангалттай хэмжээнд хэрэгжүүлж чадахгүй байгааг харж болно.

Олон улсын хадгаламжийн даатгалын байгууллагуудын түгээмэл хэрэгжүүлдэг сайн туршлагаас үзэхэд ХДБ нь банкны дампуурлаас урьдчилан сэргийлэх зорилгоор эрт арга хэмжээ авах, хүндрэлд орсон банкны дахин сэргээх тусгай бодлого хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгосон байдаг. Гэвч Монгол Улсад энэ чиглэлийн зохицуулалт хуульд тусгагдаагүй, мөн ХДК-ийн эрх мэдэл хангалтгүй байсан нь Капитал банкны эргэлтийн хөрөнгийн дутагдлыг гүнзгийрүүлж, улмаар дампууралд хүргэсэн гол шалтгаануудын нэг болсон гэж дүгнэж болно.

Дүгнэж хэлэхэд, Капитал банкны дампуурал нь МХДК-ийн анхны том сорил болж, жижиг хадгаламж эзэмшигчдийг хамгаалах үндсэн зорилго амжилттай биелсэн ч, цаашдын шинэчлэлд шаардлагатай олон асуудлыг сөхөн гаргасан юм. Үүнийг шийдвэрлэхийн тулд эрх зүйн зохицуулалтыг сайжруулж, олон улсын туршлагаас суралцах хэрэгтэй.

2.3 Хадгаламжийн даатгалын тогтолцооны олон улсын харьцуулалт: Солонгос, Япон улсын жишээн дээр

Монгол улсын ХДТ-г сайжруулахын тулд ижил төстэй улс орнуудын туршлага, хууль эрх зүйн зохицуулалтыг судлах нь үр дүнтэй. МУ-ын эрх зүйн систем, банкны бүтэцтэй төсөөтэй гэж үзэж болох Өмнөд Солонгос болон Япон улсын ХДК-ын хууль эрх зүйн орчныг судаллаа. БНСУ болон Япон улс нь манай улстай харьцуулахад илүү удаан хугацаанд үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд, хэд хэдэн санхүүгийн хямралыг даван туулсан туршлагатайгаараа онцлогтой.

2.3.1 Өмнөд Солонгос – KDIC-ийн зохицуулалтын бүтэц

БНСУ-ын Хадгаламжийн даатгалын корпорацийг (KDIC) олон улсын туршлагаас, ялангуяа Азийн санхүүгийн зах зээлийн төстэй орчинтой тул сонгон авч судлахаар шийдлээ. Өмнөд Солонгосын ХДК нь 1996 онд байгуулагдаж, Азийн санхүүгийн хямрал (1997-1998) болон түүнээс хойших олон өөрчлөлтийн явцад тасралтгүй хөгжиж ирсэн байгууллага юм.

KDIC-ийн үндсэн үйл ажиллагааг зохицуулдаг хууль нь “Хадгаламж эзэмшигчийг хамгаалах тухай хууль” бөгөөд тус улсад банкнаас гадна даатгал, үнэт цаасны компани зэрэг санхүүгийн байгууллагуудын хөрөнгө оруулагчдын мөнгөн хөрөнгийг ч хамгаалдаг цогц системтэй.

KDIC нь 1997 оны санхүүгийн хямралаас хойш эрх зүйн орчноо үе шаттайгаар өргөтгөн, өдгөө банк, санхүүгийн байгууллагуудын шийдвэрлэлтийн гол хэрэгжүүлэгчийн нэг болсон байгууллага юм. Тус корпораци нь “Loss Minimizer” буюу алдагдал бууруулагч чиг үүрэгтэйгээр ажилладаг (International Association of Deposit Insurers, Public Policy Objectives for, 2020). Өөрөөр хэлбэл зөвхөн даатгалын нөхөн төлбөр төлөөд зогсохгүй, асуудалтай банкнуудыг өөр бүтэц, хэлбэрээр авч үлдэх, эрсдэлийг бууруулах зорилгоор идэвхтэй арга хэмжээ авдаг.

Хүснэгт 2.2 БНСУ болон МУ-ын эрх зүйн орчны харьцуулалт

Улс	Засаглалын бүтцийн хувьд
БНСУ	9 дүгээр зүйл Хадгаламжийн даатгалын хорооны бүрэлдэхүүн KDIC-ийн дээд шийдвэр гаргах байгууллага нь Хадгаламжийн Даатгалын Хороо (Deposit Insurance Committee) ба 7 гишүүнээс бүрдэнэ. Энэхүү хороог KDIC-ийн өөрийн Ерөнхийлөгч тэргүүлдэг нь онцлог бөгөөд түүнээс гадна Сангийн яамны дэд сайд, Төв банк (БНСУ-ын Bank of Korea)-ны ахлах албан тушаалтан, санхүүгийн зохицуулагч

	байгууллагын төлөөлөл багтдаг. Үлдсэн гишүүдийг Сангийн сайд, Төв банкны Ерөнхийлөгч зэргээс санал болгон томилдог бөгөөд тэдгээр нь ихэвчлэн банк санхүүгийн туршлагатай хараат бус шинжээчид байдаг (Deposit Insurance Act of Korea, 1995).
Монгол улс	22 дугаар зүйл.Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо Монгол улсын БДМХДтХ-д зааснаар ХДК-ын удирдах дээд байгууллага нь Хадгаламжийн даатгалын ҮХ байна. Хуулийн дагуу тус хороо 7 гишүүнээс бүрдэх бөгөөд МБ (Төв банк)-ны тэргүүн дэд ерөнхийлөгч нь хорооны даргаар ажилладаг. Мөн Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Санхүүгийн зохицуулах хорооны нэг төлөөлөл багтана. Үлдсэн гурван гишүүнийг МБ-ны Ерөнхийлөгч, Сангийн сайд, Монголын Банкнуудын Холбооны Ерөнхийлөгчөөс тус бүр нэр дэвшүүлэн томилдог. Түүнчлэн МХДК-ийн гүйцэтгэх захирал ҮХ-ны гишүүн байна хэмээн заасан байдаг.
Харьцуулалт	
Солонгос улстай харьцуулбал, МХДК-н удирдах байгууллагын бүрэлдэхүүн нь МХДК-ийн зөвлөлийг олон талын оролцоотой болгож байгаа ч бие даасан, хараат бус байдалд нь саад учруулдаг. Тухайлбал, ҮХ-ны дарга нь Монгол банкны удирдах албан тушаалтан байх нь ЗГ эсвэл Төв банкны ны ашиг сонирхол МХДК-ийн шийдвэрт нөлөөлөх эрсдэлийг дагуулдаг. Харин БНСУ-ын хувьд KDIC өөрийн удирдлагаараа хороогоо даргалуулдаг нь ашиг сонирхлын зөрчилтэй байдлаас сэргийлдэг байна. Үндэсний хорооны олонх нь төрийн болон зохицуулагч байгууллагын төлөөлөл байгаа нь МХДК-г бодлогын хувьд бусад байгууллагаас хараат байх байдалд оруулж болзошгүй. Хорооны бүрэлдэхүүн дахь ашиг сонирхлын зөрчлийн эрсдэлийг бууруулах чиглэлээр БНСУ давуу байна. Тухайлбал, Монголын хадгаламжийн даатгалын үндэсний хороонд банкны салбарын төлөөлөл оролцох зохицуулалт (Монголын Банкнуудын холбооны санал болгосон гишүүн) нь санхүүгийн салбарын дуу хоолойг тусгах давуу талтай ч шийдвэр гаргалтад өөрийн салбарын сонирхлыг хамгаалах эрсдэл дагуулдаг. Харин БНСУ энэ төрлийн төлөөллийг хасаж, оронд нь хараат бус, мэргэжлийн гишүүдээр бүрдүүлдэг нь хорооны шийдвэрийг илүү төвийг сахисан, олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн байлгах нөхцөлийг бүрдүүлжээ. Харин Солонгос улсын хувьд ҮХ-ны 3 гишүүнийг банк санхүүгийн туршлагатай хараат бус шинжээчдээр бүрдүүлдэг нь нэг талаас төрийн оролцоог хангахын сацуу	

нөгөө талаас хадгаламжийн даатгалын байгууллагын бие даасан шийдвэр гаргах чадварыг хадгалах тэнцлийг хангадаг байна. (Deposit Insurance Act of Korea, 1995).	
Ил тод байдлыг нэмэгдүүлэх	
БНСУ	Үндэсний хорооны үйл ажиллагааг зохицуулсан 10 дугаар зүйлийн 10.3-т Хорооны дарга өөрийн хяналтаас гадуур шалтгаанаар үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон үед хадгаламжийн даатгалын хорооны гишүүд ямар дарааллаар хорооны даргын үүргийг нөхөж гүйцэтгэх талаар зохицуулсан байдаг. Мөн 10.4-р хэсэгт тогтоолыг хүчин төгөлдөрт тооцоход шаардлагатай саналын тоог тогтоож өгсөн байдгаас гадна 10.5-т хорооны хурлын тэмдэглэлд ямар мэдээллүүдийг тусгасан байх шаардлагатайг тодорхойлж олон нийтэд мэдээлэхийг үүрэг болгосон байдаг.
Монгол улс	БДМХДтХ-н 23 дугаар зүйлд Үндэсний хорооны хуралдаан Үндэсний хорооны хуралдааны явцыг албан ёсоор баримтжуулж, тэмдэглэл хөтлөх бөгөөд хуралдаанд оролцсон бүх гишүүн гарын үсэг зурж баталгаажуулна гэж хуульд заасан (3.8 дахь хэсэг). Гаргасан шийдвэр бүрийг албан тогтоол хэлбэрээр баталгаажуулж, даргаар гарын үсэг зуруулдаг.
Харьцуулалт	
Монгол улсын хувьд БНСУ-тай харьцуулахад ҮХ-ны хурал хуралдах журам, хурлын тэмдэглэлийг хөтлөн баталгаажуулах тал дээр адил заалттай. Харин Монгол улсын хувьд ҮХ хуралдах давтамжийг нарийвчлан зохицуулж өгсөн нь БНСУ-тай харьцуулахад онцлог заалт байна. Гэвч МУ нь Хадгаламжийн даатгалын хорооны үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, олон нийтийн итгэлийг хадгалахын тулд тус хороо гаргасан шийдвэр, үйл ажиллагааныхаа талаарх мэдээллийг холбогдох эрх бүхий байгууллагууд болон олон нийтэд зохих байдлаар мэдээлдэг байх шаардлага бүхий заалт шаардлагатай.	
Үйл ажиллагааны цар хүрээ, эрх мэдэл	
БНСУ	Хадгаламж эзэмшигчдийг хамгаалах тухай хуулийн 18-р зүйлд корпорацийн үйл ажиллагааны хүрээ заалтад дараах эрхийг ХДК-д олгосон байдаг : (i) актив, пассивыг өөр хэвийн үйл ажиллагаа явуулж буй банкинд шилжүүлэх буюу худалдан авах, шилжүүлэн өгөх хэлцэл хийх; (ii) түр хугацаанд ажиллуулах гүүр банк байгуулах; (iii) өөр банктай нэгтгэх, худалдан авах хэлцлийг зохион

	байгуулах; (iv) шаардлагатай бол санхүүгийн дэмжлэг олгох (шууд хөрөнгө оруулалт, зээл олгох гэх мэт); мөн эцэст нь (v) хадгаламж эзэмшигчдэд нөхөн төлбөр олгох (дампуурлын эцсийн арга хэмээн тусгасан байдаг. .
Монгол улс	БДМХДтХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т “хадгаламжийн даатгалын үйл ажиллагаа”-ны хүрээнд дараах чиг үүргүүдийг тодорхойлсон байдаг: (i) арилжааны банкнууд харилцах, хадгаламжийн дансан дахь мөнгөн хөрөнгөө ХДК-д даатгуулах; (ii) даатгалын тохиолдол үүсэхэд (банк албадан татан буугдах шийдвэр гарахад) хадгаламж эзэмшигчдэд нөхөн төлбөр олгох; (iii) банкны актив, пассивыг шилжүүлэх; (iv) тусгай зориулалтын банк байгуулах үед шилжүүлэн авч буй банкинд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагаа.
Харьцуулалт	
Солонгос Улсын Хадгаламжийн Даатгалын Корпораци (KDIC) нь хадгаламжийн даатгагчийн үүргээс гадна банк дампуурлын үед сэргээн босголт, татан буулгалтыг хэрэгжүүлэх бүрэн эрх бүхий институт юм. KDIC нь Purchase & Assumption, гүүр банк байгуулах, актив шилжүүлэх зэрэг арга хэмжээг бие даан хэрэгжүүлэх эрхтэй бөгөөд Монгол Улсын Хадгаламжийн даатгалын корпорацаас ялгаатай нь зөвхөн санхүүгийн дэмжлэг үзүүлэгч бус, бодит гүйцэтгэгч байгууллагаар ажилладаг. Гэсэн хэдий ч уг үйл ажиллагаа нь Төв банк болон санхүүгийн зохицуулагч байгууллагуудтай уялдсан хамтарсан шийдвэрийн хүрээнд явагддаг.	

2014 оноос KDIC нь санхүүгийн байгууллагуудад хамтарсан хяналт шалгалт хийх, шаардлагатай тохиолдолд сайжруулах арга хэмжээ авах эрхийг хуулиар олгосон байдаг (Deposit Insurance Act of Korea, 1995).

KDIC нь анх зөвхөн төлбөр олгодог “paybox” маягаар ажиллаж байсан бол сүүлийн 20 жилийн шинэчлэлээр банкны эрсдэлээс сэргийлэх, хямралыг идэвхтэй шийдвэрлэх мандатыг авчээ. Тухайлбал, 2014 оноос эрсдэлд суурилсан хураамжийн систем нэвтрүүлж, эрсдэл өндөр банкинд илүү шимтгэл ноогдуулдаг болсон. Мөн хуулийн нэмэлтээр KDIC нь санхүүгийн байгууллагад хамтарсан хяналт шалгалт хийх болон шаардлагатай тохиолдолд үйл ажиллагааг нь сайжруулах талаар албадлагын арга хэмжээ авах эрхтэй болсон нь ХДБ тухайн банкныг төлбөрийн чадваргүй болохоос нь өмнө үйл ажиллагааг нь сэргээх, эрсдэлийг бууруулах чиг үүрэгтэй болсон . (Deposit Insurance Act of Korea, 1995).

KDIC нь банк санхүүгийн хямралын үед зөвхөн хадгаламжийн нөхөн төлбөр олгоод зогсохгүй үйл ажиллагааны зарим хэсгийг түр хугацаанд шилжүүлэх, “чанаргүй актив”-ыг худалдан авч зохицуулах зэрэг олон төрлийн арга хэмжээ авдаг онцлогтой. Жишээ нь, 1998 оны хямралын дараа KDIC нь хөрөнгийн дутагдалд орсон хэд хэдэн банкинд хөрөнгө оруулалт хийж, өрийг төрийн сантай хамтран худалдан авч цэвэрлэн, банкны салбарыг тогтворжуулж байсан. Энэ нь шууд нөхөн төлбөр олгохоос зардал багатай байвал хэрэгжүүлдэг арга юм. Үүнээс үүдэн гарсан зарлагыг олон нийтийн (татвар төлөгчдийн) болон санхүүгийн салбарын хамтарсан эх үүсвэрээр санхүүжүүлэх эрх зүйн зохицуулалтыг чангатгаж, “Олон нийтийн хөрөнгө удирдах тухай тусгай хууль”-ийг батлан ил тод байдал, хяналтыг сайжруулсан байдаг.

KDIC-ийн цар хүрээ: KDIC-ийн онцлог нь, хэрэв тухайн асуудалтай санхүүгийн байгууллага (банк) системийн хувьд чухал нөлөөтэй бол хамгийн бага зардлын дүрмийг зөрчиж засгийн газрын тусламжтайгаар банкийн дахин сэргээн босгох уян хатан зохицуулалт байдагт оршино (Deposit Insurance of Vietnam, 2023).

Тухайлбал, БНСУ-д банкны дампуурал нь системийн тогтвортой байдалд хохирол учруулна гэж үзвэл хадгаламжийн даатгалын хорооны гишүүдийн 2/3-ын олонхоор шийдвэр гарган, “хамгийн бага зардал” зарчмыг түр орхиж, илүү зардал гарсан ч байсан урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч болдог. Ингэхдээ тухайн байгууллагыг өөрөө сэргээх зорилгоор шууд хөрөнгө оруулалт хийх, бусад банкинд нэгтгэхдээ тодорхой дэмжлэг өгөх зэргийг ашиглах боломжтой. Мөн онцгой нөхцөлд KDIC-г шүүхээс тусгай эрх бүхий итгэмжлэн удирдагч болгон томилж, асуудалтай байгууллагын актив өрийг захиран удирдуулах эрх олгодог хууль эрх зүйн зохицуулалт ч байна. Үүнийг цогцоор нь авч үзвэл KDIC нь аливаа банк санхүүгийн байгууллагыг дампуурах нөхцөлд дампуурлын өмнө, дампуурлын үеийн, дампуурлын дараах бүх шатанд оролцох бүрэн эрх мэдэлтэй, бие даасан байгууллага юм.

Түүнчлэн тус улсын санхүүгийн аюулгүйн сүлжээний оролцогчид (Сангийн яам, Санхүүгийн зохицуулагч хороо, Төв банк, ХДК г.м.) хооронд үүрэг хариуцлага маш тодорхой хуваарилагдсан, харилцан мэдээлэл солилцоо өндөр түвшинд явагддаг тул хадгаламжийн даатгагч шийдвэрлэлтэд проактив байр суурьтай ажиллах нөхцөл бүрдсэн байдаг гэж дүгнэжээ.

KDIC ба DICOМ харьцуулалт: Дээрхээс үзэхэд БНСУ-ын хадгаламжийн даатгалын систем нь Монгол улстай харьцуулвал илүү өргөн мандаттай, ялангуяа хадгаламжийн даатгагч байгууллагыг шийдвэрлэгч байгууллага болгож чадсан байна. МУ-ын ХДК нь хуульд зааснаар актив, пассив шилжүүлэх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх эрхтэй боловч

энэ нь дан зөвшөөрөгдөх үйлдлийн хүрээ болохоос биш, ХДК бие даан санаачилж, гүйцэтгэх эрх бүхий субъект биш юм. Харин KDIC нь олон тохиолдолд өөрөө шийдвэрийг гаргаж, төрийн санхүүжилт татах, шүүхийн тусгай эрх авч компанийн үйл ажиллагааг бүрэн хариуцах зэргээр илүү бие даан ажиллах нь түгээмэл байна.

2.3.2 Япон улсын хадгаламжийн даатгалын байгууллагыг зохицуулагч хууль, үйл ажиллагааны загвар

Япон улсын Хадгаламжийн Даатгалын Корпораци (DICJ) нь 1971 онд байгуулагдсан, дэлхийн хамгийн анхны хадгаламжийн даатгалын байгууллагуудын нэг юм. Япон улсын банкны салбар 1990-ээд оны дунд үеэс томоохон хямралуудтай нүүр тулж олон банк, санхүүгийн байгууллага дампуурсан. Энэ нөхцөлд DICJ нь энгийн үед ажиллаж байсан хүрээнээсээ хальж, санхүүгийн системээ аврах тусгай арга хэмжээнүүдийг гүйцэтгэх болжээ. Үүний тулд 1996 онд Япон улс Хадгаламжийн даатгалын тухай хуулийг шинэчлэн найруулж, ХДК-даа дараах нэмэлт эрх, үүргийг олгосон байдаг:

Хадгаламж эзэмшигчдэд нөхөн төлбөр олгох үндсэн үүргээс гадна банкны дампуурлын үед авах арга хэмжээг шийдвэрлэх эрх мэдэлтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг. Өөрөөр хэлбэл, банкинд санхүүгийн хүндрэл үүссэн тохиолдолд DICJ нь зөвхөн хадгаламжийн нөхөн төлбөр олгохоос гадна тухайн банкны хувь заяаг шийдвэрлэх үйл явцад голлох оролцогч болж хувирсан юм. Энэ хүрээнд хүндрэлд орсон банкны актив болон өр төлбөрийг өөр банкинд шилжүүлэх, эсвэл шаардлагатай тохиолдолд тусгай зориулалтын “түр гүүр банк” (bridge bank) байгуулан шилжүүлэн зохион байгуулах үүргийг DICJ хариуцдаг болсон (Monetary and Capital Markets Department, 2024).

МУ-н одоогийн зохицуулалттай харьцуулахад, банкны хяналт шалгалт, шийдвэрлэлттэй холбоотой үйл ажиллагааг зөвхөн МБ голлон хэрэгжүүлдэг бөгөөд ХДК нь банк дампуурсны дараа нөхөн төлбөр олгох үүрэг хүлээдэг байна. Харин Япон улсын туршлагаас үзвэл ХДБ зөвхөн төлбөрийн хэрэгжилтэд оролцох бус, банкны шийдвэрлэлтийн үйл явцад идэвхтэй оролцох, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэх эрх мэдэлтэй байна.

DICJ нь санхүүгийн дэмжлэг, хөрөнгө оруулалт хийх давхар чиг үүрэгтэй. Хямралын үед Япон улсын ЗГ ихээхэн хэмжээний хөрөнгийг татан буугдаж буй банкнуудыг аврахад зориулсан бөгөөд үүний тодорхой хэсгийг DICJ дамжуулан хэрэгжүүлжээ. Тухайлбал, зарим том банкнуудын хувьцааг тодорхой хугацаанд худалдаж авч төрийн эзэмшилд байлгах, чанаргүй зээлийн активуудыг худалдан авч “Хөрөнгө сэргээх, цуглуулах корпораци” (RCC) хэмээх охин компаниараа дамжуулан борлуулах ажлыг хийсэн байдаг. 2010 онд л гэхэд DICJ нь тус RCC компаниараа дамжуулан 29 банкны хувьцааг эзэмшдэг

байсан. Япон улсын ХДК-ийн идэвхтэй оролцоо нь банкнуудын хэвийн үйл ажиллагааг хурдан сэргээхэд тусалдаг ч даатгалын сангаас гадуур төрийн нэмэлт эх үүсвэр шаарддаг онцлогтой.

Даатгалын хамрах хүрээ: Японд банкны хадгаламжийг 10 сая иен (ойролцоогоор 65-80 мянган ам.доллар) хүртэл даатгадаг. Харин төлбөр тооцооны зориулалттай харилцах дансан дахь мөнгөнд тодорхой хугацаанд бүрэн баталгаа олгох тусгай зохицуулалт 2000-аад оны эхэн үед мөрдөгдөж байгаад 2005 оноос бүх банкнууд энгийн журамд шилжиж, 10 сая иен хүртэл л хадгаламжийг даатгах болсон. Өөрөөр хэлбэл, хямралын үед төрөөс бүх төрлийн хадгаламжид бүрэн баталгаа гаргах онцгой арга хэмжээг DICJ хэрэгжүүлж байсан түүхтэй.

Засаглал, хяналт: DICJ нь Япон улсын Сангийн яам, Санхүүгийн үйлчилгээний агентлаг (FSA) болон Төв банк (Bank of Japan)-тай гурвалсан бүтэцтэй ажилладаг. FSA нь үндсэндээ банкнуудын хяналт шалгалт, шийдвэрлэлийн бодлого гаргах үүрэгтэй, харин DICJ түүнийг гүйцэтгэх үүрэгтэй гэж үзэж болно (Patrizia Baudino, Carlos Sánchez and Ruth Walter, 2021). DICJ-ийн удирдлагын зөвлөл, шийдвэр гаргах бүтэц нь ЗГ-ын томилгооны хүмүүсээс бүрддэг тул төрийн бодлоготой нягт уялдах давуу талтай ч бие даасан байдлын талаар шүүмж байдаг. Гэхдээ DICJ нь олон жилийн туршид олон банкны дампуурлыг шийдвэрлэхдээ арилжааны банкнууд, хувийн хэвшлийн оролцоог өргөнөөр хангасан, ил тод байдлыг эрхэмлэсэн үйл ажиллагааны загвар тогтоожээ.

Тухайлбал, эргэлтийн хөрөнгөгүй болсон банкиг татан буулгахдаа хадгаламжийн нөхөн төлбөрийг барагдуулаад дуусгах бус, аль болох шинэ хөрөнгө оруулагч олох (хувийн банкнуудаас, эсвэл гаднын хөрөнгө оруулагч) замаар тэрхүү банкны хэвийн үйл ажиллагааг сэргээх, эсвэл бусад банктэй нэгтгэх алхмуудыг эхэлж эрэлхийлдэг. Уг арга хэмжээнүүд амжилт олоогүй тохиолдолд л зөвхөн түр банк байгуулах, эсвэл татан буулгах сонголтыг хэрэгжүүлдэг нь дампуурлын сөрөг нөлөөг бууруулдаг.

Япон улсын туршлагаас харахад ХДБ нь санхүүгийн хямралын үед төв банкаар хязгаарлагдахгүйгээр хөрөнгийн дутагдалд орсон банкны үйл ажиллагаанд оролцож, банкиг дахин хөрөнгөжүүлэх, шинэ хөрөнгө оруулагч олж өгөх зэргээр өргөн хүрээний чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг байна. Уг төрлийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд тавигддаг тодорхой нөхцөлүүдийг хууль эрх зүйн хүрээнд нарийн зохицуулсан байдаг.

2.4 Хямралын үеийн нөөц төлөвлөгөө-БНСУ болон Япон улсын жишээн дээр

2.4.1 БНСУ

БНСУ-ын хадгаламжийн даатгалын системийг зохицуулсан “Хадгаламж эзэмшигчийг хамгаалах тухай хууль”-д хямралын үеийн нөөц төлөвлөгөөг нарийвчлан зохицуулсан байдаг.

Тус хуулийн 26-р зүйлийн 26.2.1-т Хадгаламжийн даатгалын корпораци нь хадгаламжийн даатгалын сангийн хөрөнгө хүрэлцэхгүй болсон тохиолдолд, Засгийн газрын баталгаатайгаар хадгаламжийн даатгалын сангийн бонд гаргаж, шаардлагатай санхүүжилтийг зах зээлээс татах эрхтэй байна. Мөн хуулийн 26.2.1-т Корпораци нь Хадгаламжийн даатгалын сангийн бонд гаргахаар төлөвлөж байгаа бол бонд гаргах бүртээ уг бондыг гаргах, эргүүлэн авах хэмжээ, нөхцөл, арга хэлбэрийг тодорхойлж, Санхүүгийн үйлчилгээний хороонд тайлагнана. (Depositor protection act, 1995)

Энэхүү заалт нь БНСУ-ын хадгаламжийн даатгалын тогтолцоонд хямралын үеийн онцгой санхүүжилтийн нөөц механизмыг шууд хуульчилсан заалт юм. Өөрөөр хэлбэл, банкны системд олон банк нэгэн зэрэг дампуурах нөхцөл үүсвэл KDIC нь урьдчилан хуримтлуулсан сангаас гадна өрийн хэрэгсэл ашиглан санхүүжилт татах боломжтой байхаар зохицуулсан байна.

2.4.2 Япон улс

Санхүүгийн системд ноцтой саатал, хямрал үүсэх эрсдэлтэй гэж үзсэн тохиолдолд Хадгаламжийн даатгалын корпораци нь банкны тогтвортой байдлыг хангах зорилгоор хямралын удирдлагын тусгай данс нээж, уг дансаар дамжуулан санхүүгийн дэмжлэг, дахин хөрөнгөжүүлэлт, банкны үйл ажиллагааг тогтворжуулах арга хэмжээг санхүүжүүлж болно хэмээн Япон улсын Хадгаламжийн даатгалын тухай хуульд заасан байдаг.

Япон улсын онцлог нь хадгаламжийн даатгалын ердийн сангаас тусдаа, зөвхөн системийн хямралд зориулагдсан тусгай сан-г хуульчилсан явдал юм. Энэ нь хямралын үед даатгалын сангийн үндсэн үүргийг алдагдуулахгүйгээр банкны салбарт идэвхтэй оролцох боломжийг бүрдүүлдэг.

Хадгаламжийн даатгалын тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.1-т Хадгаламжийн даатгалын хураамж болон сангийн хөрөнгө нь хадгаламж эзэмшигчдэд нөхөн төлбөр олгох, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад хүрэлцэхгүй болсон тохиолдолд Засгийн газар Хадгаламжийн даатгалын корпорацид төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлж болно хэмээн заасан бөгөөд тус заалт нь Япон улсад хадгаламжийн даатгалын тогтолцоог

төрийн баталгаатай хамгаалалтын сүүлчийн механизмаар хангаж өгсөн зохицуулалт юм. Ингэснээр хямралын үед олон нийтийн итгэл алдагдахаас сэргийлэх бодлогын баталгаа бүрддэг.

Мөн хуулийн 126-р зүйлийн 126.1-т Хадгаламжийн даатгалын корпораци нь хямралын үед шаардлагатай санхүүжилтийг бүрдүүлэх зорилгоор Ерөнхий сайд болон Сангийн сайдын зөвшөөрлөөр бусад этгээдээс зээл авах, мөн хадгаламжийн даатгалын корпорацийн бонд гаргах эрхтэй байна. Энэхүү заалт нь Япон улсын хадгаламжийн даатгалын байгууллагад өргөн хүрээтэй санхүүжилтийн уян хатан боломж олгож, хямралын үеийн нөөц төлөвлөгөөг хууль зүйн хувьд бүрэн баталгаажуулсан байна.

Харьцуулалт:

БНСУ болон Япон Улсын хадгаламжийн даатгалын корпорацуудын хямралын үеийн нөөц төлөвлөгөө нь тус тусын салбар хуулиудад тодорхой зүйл, заалтаар хуульчлагдсан байна. Тухайлбал, БНСУ-ын *Хадгаламж эзэмшигчийг хамгаалах тухай хууль*-ийн 18, 26.2 дугаар зүйлүүдэд хадгаламжийн даатгалын сангийн удирдлага, бонд гаргах замаар онцгой санхүүжилт татах эрхийг тогтоосон бол Япон улсын *Хадгаламжийн даатгалын тухай хууль*-ийн 121, 125, 126 дугаар зүйлүүдэд хямралын үеийн тусгай данс, Засгийн газрын санхүүгийн дэмжлэг, зээл болон бондын механизмыг нарийвчлан зохицуулсан байна. Эдгээр зохицуулалт нь хадгаламжийн даатгалын байгууллагыг хямралын үед санхүүгийн тогтвортой байдлыг хангахад идэвхтэй оролцогч институт болгон төлөвшүүлснийг харуулж байна.

2.5 Олон Улсын Хадгаламжийн Даатгалын 16 Зарчим ба Монгол Улсын Хэрэгжилтийн Үнэлгээ

ХДТ нь банкны секторт итгэх итгэлийг нэмэгдүүлж, санхүүгийн тогтвортой байдлыг хамгаалах чухал механизм болдог. Олон Улсын Хадгаламж Даатгагчдын Холбоо (IADI) болон Базелийн Банкны Хяналтын Хороо (BCBS) хамтран 2009 онд “Хадгаламжийн даатгалын үр нөлөөтэй тогтолцооны үндсэн зарчмууд”-ыг боловсруулсан бөгөөд 2014 онд санхүүгийн хямралаас авсан сургамжид тулгуурлан шинэчлэн найруулсан байдаг (IADI, 2009).

Энэхүү 16 үндсэн зарчим нь хадгаламжийн даатгалын олон улсын сайн туршлагыг тогтоосон баримт бичиг бөгөөд улс орнууд өөрсдийн даатгалын тогтолцоог үнэлж, сайжруулахад ашигладаг стандарт юм (David Walker, 2018).

Монгол Улс 2017 онд IADI-д гишүүнээр элсэж, өөрийн даатгалын тогтолцоог олон улсын стандарттай нийцүүлэх чиглэлд анхаарч ажиллаж байна.

IADI-ийн 16 үндсэн зарчмын тус бүрийг товч танилцуулж, Монгол улсын хадгаламжийн даатгалын орчныг зохицуулсан хууль эрх зүй, байгууллагын тогтолцооны хүрээнд хэрхэн хэрэгжиж буйг (бүрэн, хэсэгчлэн буюу хангагдаагүй эсэх) үнэлэн дүгнэв.

Хүснэгт 2.3 IADI-ийн 16 үндсэн зарчим тус бүрийн Монгол Улсад хангалтын байдлыг дүгнэв

Үндсэн зарчим	Монгол Улсад нийцэл
1. Нийтийн бодлогын зорилго	Бүрэн нийцсэн
2. Мандат ба эрх мэдэл	Бүрэн нийцсэн
3. Засаглал	Хэсэгчлэн нийцсэн
4. Аюулгүйн сүлжээний харилцаа	Хэсэгчлэн нийцсэн
5. Хил дамнасан асуудлууд	Одоогоор хамаарахгүй (нийцэлд нөлөөгүй)
6. Хямралын бэлэн байдал, менежмент	Хэсэгчлэн нийцсэн
7. Гишүүнчлэлийн хамрах хүрээ	Бүрэн нийцсэн
8. Даатгалын хамгаалалтын хэмжээ	Бүрэн нийцсэн
9. Сангийн эх үүсвэр, ашиглалт	Хэсэгчлэн нийцсэн
10. Олон нийтийн мэдлэг, мэдээлэл	Хэсэгчлэн нийцсэн
11. Хууль эрх зүйн хамгаалалт	Нийцээгүй
12. Буруутай этгээдэд хариуцлага тооцох	Нийцээгүй
13. Эрт илрүүлэлт, оролцоо	Хэсэгчлэн нийцсэн
14. Дампуурлыг шийдвэрлэх механизм	Хэсэгчлэн нийцсэн
15. Нөхөн төлбөрийн шуурхай байдал	Хэсэгчлэн нийцсэн
16. Нөхөн олговор эргүүлэн авах	Бүрэн нийцсэн

Зарчим бүрийг тусад нь авч үзэж, дээрх үнэлгээг хийх болсон үндэслэлээ хууль, практиктай холбон дэлгэрэнгүй тайлбарлав. Мөн хэсэгчлэн нийцсэн болон нийцээгүй зарчим бүр дээр шаардлагатай хууль эрх зүйн өөрчлөлтийн саналыг дурдав.

1) Нийтийн эрх ашгийг хамгаалах бодлогын зорилго

Зарчмын агуулга: ХДТ-ны гол зорилго нь хадгаламж эзэмшигчдийг хамгаалах болон санхүүгийн тогтвортой байдлыг хангах явдал юм. Энэ зорилтыг хууль буюу холбогдох баримт бичгүүдэд албан ёсоор тодорхойлон тусгаж, олон нийтэд

нээлттэй мэдээлсэн байх шаардлагатай. Түүнчлэн даатгалын тогтолцооны бүх зохицуулалт, загвар нь эдгээр зорилгод нийцэж байх ёстой.

Монгол Улсад: Монгол Улсын БДМХДтХ нь 1-р зүйл (оршил, зорилго) хэсэгтээ дээрх хоёр зорилгыг товч тодорхойлсон. Тус хуульд “...иргэн, хуулийн этгээдийн банкинд хадгалуулсан мөнгөн хадгаламжийг хамгаалах, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах...” гэж заасан нь хадгаламж даатгалын үндсэн зорилго, олон нийтийн ашиг сонирхлыг хамгаалсан заалт байна. Ийнхүү хуульд зорилгоо албан ёсоор тунхаглаж, олон нийтэд хууль эрх зүйн мэдээллийн сүлжээгээр (legalinfo.mn) нийтэлсэн тул зарчмын энэ хэсгийг бүрэн хангаж байна.

МБ болон ХДК нь хадгаламжийн даатгалын тогтолцооны хэрэгжилт зорилгоо хэрхэн биелүүлж буйд тогтмол үнэлгээ хийх ажлыг шат дараатай эхлүүлжээ. Гэвч тогтмол (жишээ нь 5 жил тутам) хараат бус дүгнэлт гаргах механизм одоогоор тусгайлан зохицуулагдаагүй байгаа тул зорилго биелэлтийг хянах дунд хугацааны хараат бус үнэлгээ хийх эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай.

Санал: БДХДтХ-д нэмэлт оруулж, зорилго биелэлтийг хянан үнэлэх талаар зохицуулалт оруулах нь зүйтэй (жишээлбэл, Үндэсний хороогоор 5 жил тутам өөрийн үнэлгээ хийлгэж, тайланг олон нийтэд мэдээлэх, эсвэл хараат бус аудит, МБ-ны үнэлгээ хийх заалт). Энэ нь нэгдүгээр зарчимд заасан зорилгуудыг тогтмол мөрдөж буй эсэхэд итгэл үзүүлэх, олон нийтийн итгэлийг бататгахад чухал ач холбогдолтой.

2) Чиг үүрэг ба эрх мэдэл

Зарчмын агуулга: ХДБ-ын чиг үүрэг (мандат) болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх мэдэл, бүрэн эрх нь хуульд тодорхой заагдсан, бусад оролцогч байгууллагуудын (төв банк, хяналтын байгууллага гэх мэт) чиг үүрэгтэй уялдсан байх ёстой. ХДБ-ын мандат нь түүний эрх мэдлийн цар хүрээ, хязгаарыг тогтоодог. Жишээлбэл, ХДБ нь дараах эрхүүдтэй байхыг үндсэн зарчимд онцолдог: даатгалын хураамж, шимтгэлийг тогтоон хураах; шаардлагатай тохиолдолд нэг банкаас нөгөөд хадгаламж, төлбөр шилжүүлэх; даатгагдсан хадгаламж эзэмшигчдэд нөхөн төлбөр олгох; банкнуудаас үйл ажиллагааны мэдээлэл шуурхай, бүрэн хэмжээгээр авах; санхүүгийн аюулгүйн сүлжээнд мэдээлэл хуваалцах; банкнуудыг хууль ёсны үүргээ биелүүлэхийг шаардах; өөрийн үйл ажиллагааны төсөв, бодлого, журам гаргах; гэрээ хэлцэл байгуулах зэрэг.

Монгол Улсад: ХДБ-ын чиг үүрэг нь дээрх зарчмын хүрээнд хуульд тодорхой тусгагдсан. ХДК нь хуульд зааснаар албан журмын даатгалын үйл ажиллагааг хэрэгжүүлэх үндсэн үүрэгтэй, ашгийн төлөө бус хуулийн этгээд юм. Түүний гол үүрэг нь гишүүн банкнуудаас даатгалын хураамж төвлөрүүлж даатгалын сан бүрдүүлэх, шаардлагатай үед хадгаламж эзэмшигчдэд нөхөн төлбөр олгох явдал болно.

Эрх мэдлийн хувьд, хуульд ХДК-д банкнуудаас даатгалын хураамж, шимтгэл тогтоох, хураах эрхийг олгосон (бүх банкинд даатгалын хураамжийг улирал тутам төлөх үүрэг оногдуулсан). Мөн даатгалын сангийн хөрөнгийг захиран зарцуулах, өөрийн үйл ажиллагаанд бие даан шийдвэр гаргах эрхийг ХДК-д олгож, ҮХ нь бодлого, шийдвэрийн түвшинд удирдлагаар хангах бүтэцтэй. Гишүүн банкнууд ХДК-д шаардлагатай мэдээлэл, өгөгдлийг нийлүүлэх үүрэгтэй нь хууль, журмаар зохицуулагдсан.

Ийнхүү Монголын ХДБ-ын мандат, эрх мэдлийг хуульчилсан байдал нь үндсэн зарчимд нийцэж байгаа тул бүрэн хангагдсан гэж үнэлэв.

Санал: Мандат, эрх мэдэл хангалттай боловч практикт хэрэгжүүлэхдээ бусад аюулгүйн сүлжээний оролцогчидтой роль давхцахгүй, тодорхой байхаар улам сайжруулах нь зүйтэй. Тухайлбал, банкны хяналт, зохицуулалт (МБ) болон даатгагчийн хооронд мэдээлэл, эрх мэдлийн давхцалгүй байх нөхцөлийг эрх зүйн актаар улам тодруулах (харилцан мэдээлэл солилцох гэх мэт) хэрэгтэй.

3) Засаглал

Зарчмын агуулга: ХДБ нь үйл ажиллагааны хувьд бие даасан, сайн засаглалтай (удирдлагын бүтэц нь чадварлаг, хариуцлагатай), үйл ажиллагаа нь ил тод, нээлттэй, шийдвэр гаргалт нь аливаа улс төр, бизнесийн нөлөөнөөс ангид байх ёстой. Мөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлагад тавигдах шалгуур, томилох, огцруулах процессыг ил тод болгож, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх зохицуулалт хэрэгтэй. Засаглалын хувьд даатгалын байгууллага нь өөрийн шийдвэрийн хэрэгжилт, сангийн зарцуулалтдаа хариуцлага хүлээж, хөндлөнгийн хяналтад орох ёстой.

Монгол Улсад: ХДК-ийн хувьд засаглалын бүтэц нь хууль болон байгууллагын дүрмээр тодорхойлогдсон. ҮХ нь бодлого тодорхойлох дээд байгууллага бөгөөд гишүүдэд нь Сангийн яам, Монгол банк зэрэг институцийн төлөөлөл багтдаг. ХДК-ийн гүйцэтгэх удирдлагыг ҮХ томилж, үйл ажиллагааны тайланг нь хэлэлцдэг тогтолцоотой.

ХДК нь төрийн өмчит байгууллага тул байгууллагын хараат бус байдал хангалтгүй байна. Тухайлбал, сангийн хөрөнгийг зарцуулах, томилгоо хийхэд улс төрийн нөлөө орж болзошгүй эрсдэлтэй.

Засаглалын хууль эрх зүйн орчны нэг сул тал нь ХДК-ийн албан тушаалтнуудад ёс зүйн дүрэм, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх журам хангалттай тодорхой биш байж магадгүй. Одоогоор ил болоогүй ч, дотоод аудит, хяналтын тогтолцоог сайжруулах нь олон улсын зарчимд нийцүүлэх нэг чиглэл болно. Дүгнэвэл, Монголын хадгаламжийн даатгалын байгууллагын засаглал зарим үзүүлэлтээр сайжруулах шаардлагатай тул хэсэгчлэн нийцсэн байна. Үндсэн зорилгоо хэрэгжүүлэх чадавх, ил тод байдал өсөж байгаа ч бие даасан байдал, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчим хууль, дүрэмд бүрэн тусгагдаагүй байна. Санал: Засаглалыг бэхжүүлэхийн тулд хэд хэдэн хуулийн өөрчлөлт, арга хэмжээ шаардлагатай.

4) Аюулгүйн сүлжээний оролцогчидтой харилцах нь

Зарчмын агуулга: ХДБ нь төв банк, банкны хяналт шалгалтын байгууллага, Сангийн яам зэрэг санхүүгийн аюулгүйн сүлжээний бусад оролцогч байгууллагуудтай нягт уялдаатай ажиллах ёстой. Үүний тулд хууль, журам эсвэл харилцан ойлголцлын санамж бичгээр мэдээлэл солилцох, хамтран ажиллах албан ёсны зохицуулалтыг бий болгосон байх шаардлагатай. Ялангуяа банкнууд дээр томоохон хяналт шалгалтын арга хэмжээ авах, эсвэл хямралын нөхцөл үүсэхэд эдгээр байгууллагууд шуурхай мэдээлэл хуваалцаж, тохирсон арга хэмжээ авах нь чухал.

Монгол Улсад: Одоогоор МБ, ХДК нар нь мэдээлэл солилцох талаар тодорхой санамж бичигтэй эсэх нь олон нийтэд ил тод мэдээлэл хомс.

5) Хил дамнасан асуудлууд

Зарчмын агуулга: Гадаадын банкны салбар, охин компаниуд тухайн улсад үйл ажиллагаа явуулдаг бол ХДБ нь ижил төстэй байгууллагуудтайгаа олон улсын хэмжээнд мэдээлэл солилцох зарчимтай уялдах хэрэгтэй. Тухайлбал, нэг банк хоёр улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд даатгалд хамрагдах тохиолдолд аливаа давхардлыг зохицуулах, даатгалын төлбөр олгох үүргийг нь тодорхой болгох хоёр талын гэрээ байх шаардлагатай.

Монгол Улсад: Манай улсын хувьд банкны системд гадаад улсын банк үйл ажиллагаа явуулдаггүй, бүх банкнууд Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд (дотоодын банкнууд) байна. Зарим банкнууд гадаад хувь эзэмшигчтэй байж болох

ч хадгаламжийн даатгалын хамрах хүрээний асуудал зөвхөн Монгол Улсад бүртгэлтэй банкнуудаар хязгаарлагдаж байна. Иймээс энэ зарчим одоогоор онц нөлөө үзүүлэхгүй байгаа юм.

Харин ирээдүйд Монгол Улсад гадаадын банкны салбар нэвтрэх эсвэл Монгол банкинд гадаадад салбар байгуулах нөхцөл үүсвэл урьдчилан энэ чиглэлээр эрх зүйн бэлтгэл хангах нь зүйтэй. Тухайлбал, Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж буй гадаадын банкны салбарын хадгаламжийг манай ХДК даатгах уу, эсвэл эх орны (товчхондоо толгой банкны орон) даатгалын системд хамруулах уу гэдгийг хууль болон хоёр талын хэлэлцээрээр тодорхой болгох хэрэгтэй. Одоогийн БДМХДтХ-д энэ талаар тодорхой заалт байхгүй тул шаардлагатай тохиолдолд нэмэлт зохицуулалт оруулах боломжтой.

6) Хямралын менежмент

Зарчмын агуулга: ХДБ нь онцгой байдлын үед мөрдөх төлөвлөгөө, хямралын менежментийн бодлого, журмуудтай байх ёстой. Ингэснээр банк дампуурах, санхүүгийн хямралд орох үед түргэн шуурхай арга хэмжээ авч чадна. Мөн системийн хэмжээний санхүүгийн хямралын үед аюулгүйн сүлжээний бүх байгууллага хамтран үндэсний хэмжээний хямралын нөөц төлөвлөгөөг урьдчилан боловсруулж, түүнийгээ тогтмол туршиж сайжруулдаг байх шаардлагатай.

Монгол Улсад: ХДК нь хямралын үеийн нөөц төлөвлөгөөгүй бөгөөд 2019 оны Капитал банкны дампуурал ХДК-ийн хувьд анхны бодит сорилт байсан бөгөөд тухайн үед ямар нэгэн төлөвлөгөөгүйгээр яаралтай шийдвэрүүдийг гаргаж хэрэгжүүлсэн. Хадгаламжийн даатгалтай холбоотой мэдээллийг хямралын үед олон нийтэд хүргэх, хөрөнгө оруулагчдад итгэл төрүүлэх, олон нийтэд шуурхай мэдээлэх зэрэг зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь ХДК бие даан гардан хийх чадвартай болох хэрэгтэй байдаг. Манай ХДК-ийн хямралын үед гүйцэтгэх үүрэг голчлон даатгагдсан хадгаламжид нөхөн төлбөр олгох хэсэгт төвлөрч байна. Харин хямралыг бүхэлд нь шийдвэрлэх стратегийн түвшинд манай ХДК оролцох институцийн зохицуулалт дутуу байна.

Хямралын үеийн нөөц төлөвлөгөөтэй байхыг хуульд зайлшгүй тусгах шаардлагатай. Үүнд ямар мэдээлэл ямар хугацаанд цуглуулах, ямар банктай хамтрах, олон нийтэд хэрхэн мэдээлэх, санхүүжилтийн эх үүсвэр хүрэлцэхгүй бол яах зэргийг тусгасан байх. Ингэснээр ямар ч гэнэтийн тохиолдолд ХДК бэлэн байх боломжтой.

7) Гишүүнчлэл

Зарчмын агуулга: Хадгаламжийн даатгалын системийн гишүүнчлэл нь бүх банкнуудад албан журмын (заавал) байх ёстой. Банкны өмчийн хэлбэрээс үл хамааран (төрийн өмчит, хувийн, гадаадын хөрөнгө оруулалттай гэх мэт) бүгд хамрагдах нь чухал. Ингэснээр даатгалын хамрах хүрээ нийт банкны системд жигд үйлчилж, аливаа гишүүн бус банкны хадгаламж эзэмшигчид хохирох эрсдэл арилна. Гишүүнчлэл олгох, цуцлах нөхцөл, журам нь ил тод байх хэрэгтэй.

Монгол Улсад: БДМХДтХ-д Монгол банкнаас зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулж буй бүх арилжааны банкнууд уг системийн гишүүн байна гэж заасан. Хуульд банк шинээр байгуулагдахад хадгаламжийн даатгалд шууд хамрагдах үүрэг хүлээлгэх зохицуулалт бий. Иймд Монгол Улсад даатгалын гишүүнчлэл бүрэн хангагдсан. Энэ нь олон улсын зарчимд нийцэж буй бөгөөд бүх банкнууд адил шаардлага биелүүлж, даатгалын шимтгэлээ төлж байна.

8) Даатгалын хамгаалалтын хамрах хүрээ

Зарчмын агуулга: Хадгаламжийн даатгалын хамгаалалтын дээд хэмжээ болон хамрах хадгаламжийн төрлийг тодорхой, ойлгомжтой тогтоох шаардлагатай. Даатгалын хамгаалалт нь хязгаарлагдмал хэмжээтэй байх нь зүйтэй (хязгааргүй хамгаалалт нь ёс зүйгүй эрсдэлийг өдөөх тул). Энэ хязгаар нь ихэнх жижиг хадгаламж эзэмшигчдийг бүрэн хамгаалахуйц өндөр, гэхдээ нийт хадгаламжийн үнэ цэнийн тодорхой хувийг зах зээлийн эрсдэлд өртүүлсэн хэвээр үлдээхүйц хэмжээнд тогтоогдоно гэсэн үг. Мөн хамгаалалтын хамрах хүрээ (аль төрлийн данс орж, алийг нь оруулахгүй гэх мэт) тодорхой байх ёстой.

Монгол Улсад: Хадгаламжийн даатгалын хамрах хүрээг хууль болон холбогдох журмаар тодорхой тогтоосон. 2013 оны хууль батлах үед даатгалын нөхөн төлбөрийн дээд хэмжээг 20 сая төгрөг гэж тогтоожээ. Энэ дээд хэмжээ нь тухайн үед (2013 онд) Монгол Улсын нэг хадгаламж эзэмшигчийн дундаж хадгаламжийг бүрэн хамгаалахаар хэмжээ байсан. Даатгалын дээд хэмжээ, хамрах хүрээг тодорхой хугацаа өнгөрсний дараа дахин хянах шаардлагатайг IADI зөвлөмжид дурддаг (дор хаяж 5 жил тутам).

Санал: Даатгалын дээд хэмжээг тодорхой хугацааны дараа шинэчлэх механизмыг хуульчлах. Жишээлбэл, 5 жил тутам инфляцийн түвшин, банкны системийн өсөлттэй уялдуулан даатгалын дээд хэмжээг хянаж, шаардлагатай бол өөрчлөх.

9) Сангийн эх үүсвэр ба ашиглалт

Зарчмын агуулга: Даатгалын сан нь урьдчилан бүрдүүлэх (ex-ante) зарчмаар санхүүжиж, эрсдэл тохиолдсон үед хуримтлуулсан хөрөнгөөс нөхөн төлбөрийг

гаргах нь оновчтой гэж үздэг. Даатгалын сангийн хөрөнгийн эх үүсвэр нь голчлон гишүүн банкнуудын төлсөн шимтгэл, хураамж байна. Мөн даатгалын санг хүрэлцэхгүй үед нэмэлт санхүүжилтийн хувилбарыг (жишээлбэл, төв банкны зээл, засгийн газрын баталгаа) урьдчилан зохицуулсан байх ёстой. Сангийн хөрөнгийг аюулгүй, хөрвөх чадвартай хэлбэрээр хадгалах, хөрөнгө оруулалтыг нь эрсдэл багатай байлгах бодлого шаардлагатай.

Монгол Улсад: ХДС нь 2013 оноос хойш урьдчилан хуримтлуулж эхэлсэн. 2019 оны байдлаар тус сангийн хэмжээ 438.4 тэрбум хүрсэн. Хуульд ХДК нь сангийн хөрөнгийг хэрхэн удирдах талаарх нарийвчилсан заалтууд байгаа (жишээ нь, зөвхөн Засгийн газрын баталгаатай хэрэгсэлд хөрөнгө оруулах гэх мэт). Дүгнэвэл, даатгалын сангийн санхүүжилт, ашиглалтын тал дээр Монгол Улс хэсэгчлэн нийцсэн байна. Урьдчилсан сан бүрдүүлэлт, банкнуудын хариуцлага, хөрөнгийн хадгалалт зэргээр сайн талууд байгаа ч, зорилтот сангийн түвшин, яаралтай үед нэмэлт эх үүсвэр татах зохицуулалт, мөн санг уян хатан ашиглах эрх мэдлийн хувьд ахиц хэрэгтэй.

Санал: Санг уян хатан ашиглах эрх зүйн орчин бүрдүүлэх: Даатгалын санг төлбөр олгохоос гадна, хэрэв банкныг татан буулгах биш өөр хэлбэрээр шийдвэрлэх нь даатгалын санд бага зардалтай байвал (өгөөжтэй бол) тус арга хэмжээг санхүүжүүлэх зөвшөөрлийг хуульд тусгах талаар судлах. Жишээлбэл, Хадгаламжийн даатгалын сангийн хөрөнгийг гишүүн банкны үйл ажиллагааг тасралтгүй хадгалах, хадгаламж эзэмшигчдийн тасалдалгүй үйлчилгээг хангах зорилгоор ашиглаж болно, гэхдээ үүнд тавигдах нөхцөл нь даатгалын сангийн оролцоо нь татан буулгах сонголтоос санхүүгийн хувьд зардал багатай байх, хадгаламж даатгалын ҮХ, МБ болон Сангийн яам хамтран зөвшөөрсөн байх гэх мэт нарийвчилсан нөхцөлтэй заалт оруулж болно. Энэ нь зарчим 14-той давхцах ч сангийн ашиглалт талаас нь энд дурдав.

10) Олон нийтийн мэдлэг, мэдээлэл

Зарчмын агуулга: Олон нийт хадгаламжийн даатгалын тогтолцооны ач холбогдол, үйлчлэх хүрээ, хязгаарлалтыг сайн мэддэг байх нь санхүүгийн тогтвортой байдалд чухал. Иргэд өөрсдийн хадгаламж хамгаалагдсан эсэх, ямар хэмжээнд хүртэл даатгагдсан, хэрэв банк нь дампуурвал ямар үйл явц өрнөхийг урьдчилан ойлгосноор аливаа худал мэдээлэл, цуурхлаас үүдэх сандрал багасдаг. Иймээс хадгаламжийн даатгагч болон банкнууд тогтмол сурталчилгаа, боловсролын ажил хийх ёстой.

Монгол Улсад: ХДК нь албан ёсны веб сайт ажиллуулж, түүн дээрээ хууль, дүрэм, түгээмэл асуулт хариулт, даатгалын тохиолдолд хэрхэн төлбөр авах тухай зааварчилгаа байршуулсан. Гэвч тус веб сайтын хандалт харьцангуй бага, иргэд төдийлөн мэддэггүй тал бий. 2019 оны Капитал банк татан буугдсанаас хойш иргэд ХД-ын талаар ерөнхий ойлголттой болсон. Зарим иргэд “банкин дахь бүх хадгаламжийг төр баталгаажуулдаг” гэж эндүүрэх явдал байдаг. Үүнийг залруулахын тулд ХДК нь үе судалгаа хийж, олон нийтийн мэдлэгийн түвшинг тогтоон, шаардлагатай бол нэмэлт сурталчилгаа явуулах нь зүйтэй. Дүгнэлт: Монгол Улсад ХД-ын талаарх олон нийтийн мэдлэг тийм ч хангалттай бус байна.

11) Хууль эрх зүйн хамгаалалт

Зарчмын агуулга: ХДБ болон түүний одоогийн болон өмнө ажиллаж байсан ажилтнууд нь өөрийн үүргээ шударгаар хэрэгжүүлсний төлөө иргэний болон захиргааны хариуцлагад шууд татагдахгүй байх эрх зүйн дархлаатай байх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, ХДС-ийн менежер, ҮХ-ны гишүүд нь хууль, дүрэм журмын хүрээнд гаргасан шийдвэрийнхээ төлөө шүүхэд дуудагдаж, өөрийн хөрөнгөөр хариуцлага хүлээхээс хамгаалагдсан байх ёстой. Энэ нь мэдээж санаатай буруугаар ашигласан, ноцтой хайхрамжгүй үйлдэл гаргасан тохиолдолд хамаарахгүй, харин корпорацийн тусын тулд гаргасан шийдвэр нь хожим буруудсан ч хувь хүнийг яллах үндэс болох ёсгүй гэсэн үг.

Монгол Улсад: БДМХДтХ-д албан тушаалтнуудын эрх зүйн хамгаалалтын талаар тодорхой заалт байхгүй байна. Тухайлбал, ҮХ-ны гишүүн эсвэл ХДК-ийн гүйцэтгэх захирал нь нөхөн төлбөр олгохдоо буруу шийдвэр гаргасан, эсвэл сангийн хөрөнгийг буруу удирдсан хэмээн хожим шүүмжлэлд өртвөл түүнд ямар нөхцөлд хариуцлага хүлээлгэх ямар тохиолдолд хариуцлагаас чөлөөлөх нь тодорхой бус. Манай улсад одоогоор хадгаламжийн даатгалтай холбоотой шүүхийн маргаан гараагүй байгаа ч цаашид гарахгүй гэсэн баталгаа үгүй.

ХДК-ийн Үндэсний хороо, удирдлагын гаргасан нөхөн төлбөр олгох шийдвэр, сангийн хөрөнгийг зарцуулахтай холбоотой шийдвэр нь хуульд нийцсэн үндэслэлтэй байсан нөхцөлд хариуцлага хүлээлгэхгүй гэдгийг хуульд тодорхой заах нь зүйтэй.

Одоогийн нөхцөлд ХДК-ийн ажилтнууд эрх зүйн хамгаалалтгүй байна. Энэ нь эргээд ажилтнууд шийдвэр гаргахдаа болгоомжлох, хэт аюулгүй байдал баримталж шинэ санаачилга гаргахаас зайлсхийх сөрөг талтай. Иймд Монгол Улсад зарчим 11 хангалтгүй буюу нийцээгүй байна гэж үзэв.

Санал: БДМХДтХ-д эрх бүхий этгээдүүдийг хамгаалсан зохицуулалт нэмэх. Үүнд “ХДК, ҮХ-ны гишүүд болон ажилтнууд нь өөрсдийн үүрэг, эрх мэдлийн хүрээнд үндэслэлтэй гаргасан шийдвэр, үйл ажиллагааны улмаас учирсан хохирлын төлөө иргэний болон эрүүгийн хариуцлага хүлээхгүй” гэх мэт заалт оруулах. Мөн “санаатай эс үйлдэх, ноцтой хайхрамжгүй үйлдэл, авлига, албан тушаалын гэмт хэрэг гаргасан нь тогтоогдвол энэхүү хамгаалалт үйлчлэхгүй” гэдгийг давхар зааж тодруулах хэрэгтэй.

12) Банкны дампууралд буруутай этгээдүүдэд хариуцлага тооцох нь

Зарчмын агуулга: Банк санхүүгийн байгууллага дампуурч, ХДС-аас нөхөн төлбөр гарсан бол уг алдагдалд буруутай этгээдүүдээс нөхөн төлбөр нэхэмжлэх эрх бүхий байхыг зарчим шаардана. Өөрөөр хэлбэл, банкны удирдлагын хайхрамжгүй, эсвэл хууль бус үйлдлээс үүдэн банк дампуурвал ХДБ (эсвэл бусад зохицуулагч) тэднээс шүүхийн журмаар хохирол барагдуулах, эсвэл наад зах нь эрүүгийн хэрэг үүсгүүлэх эрхтэй байх ёстой. Энэ нь ёс зүйн эрсдэлийг (морал хазард) бууруулах зорилготой банкны эзэд, захирлууд хадгаламжийн даатгал нөхөн төлбөр олгочихно гээд тоомжиргүй авирлах явдлыг хязгаарлах хэрэгсэл юм.

Монгол Улсад: Банкны төлбөрийн чадваргүй болсонд буруутай этгээдүүдэд хариуцлага хүлээлгэх ажиллагааг ерөнхийдөө МБ, хууль хяналтын байгууллагууд хариуцдаг. ХДК дангаараа шүүхэд зарга мэдүүлж, хохирол нэхэмжлэх эрхийг хуулиар олгоогүй. ХДС-аас төлсөн нөхөн төлбөр нь банкны удирдлагын буруутай шийдвэрээс үүдэн гарсан бол ХДК тэр мөнгөө буруутай этгээдүүдээс нэхэмжлэн авах ёстой. Гэвч одоогоор МУ-ийн хувьд энэ харилцааг зохицуулсан хуулийн заалт, механизм байхгүй.

13) Эрт илрүүлэлт, цаг үеийн оролцоо

Зарчмын агуулга: Банк санхүүгийн байгууллагын асуудлыг хэт хурцдахаас өмнө эрт шатанд илрүүлж, түргэн арга хэмжээ авах нь хадгаламж эзэмшигчдийг хамгаалах, санхүүгийн тогтвортой байдлыг хадгалахад чухал. Ийм учраас санхүүгийн аюулгүйн сүлжээний зохицуулалт нь асуудалтай банкиг эрт илрүүлэх, шуурхай оролцох механизмыг бүрдүүлж, түүнд ХДБ-г оролцуулсан байхыг шаарддаг. Өөрөөр хэлбэл, банкны үзүүлэлт муудах, зохистой харьцаанууд алдагдах үед зөвхөн хяналт шалгалтын байгууллага бус хадгаламжийн даатгагч ч мэдээлэл авч, хэрэгцээтэй арга хэмжээнд хамтран ажиллана.

Монгол Улсад: Банкнуудын үйл ажиллагааг МБ хянан зохицуулж, сэрэмжлүүлэх, өөрийн эрхийн хүрээнд сануулга өгөх арга хэмжээ авдаг. ХДК уг хяналт,

оролцооны процесст албан ёсоор оролцдоггүй байна. МБ аливаа нэгэн банкинд онцгой арга хэмжээ авах (түр удирдлага тавих, үйл ажиллагааг хязгаарлах гэх мэт) шийдвэр гаргахдаа ХДК-ийг урьдчилан мэдээлэх эсвэл хамтран зөвшилцөх талаар хуульд үүрэг хүлээгээгүй. Мөн банк санхүүгийн хямралын эхний шинж тэмдэг илрэхэд (жишээ нь банкнуудад хадгаламж татах хөдөлгөөн ажиглагдах үед) МБ, ХДК хоёр шуурхай уулзан хэлэлцэж, шаардлагатай бол хамтарсан мэдэгдэл гаргах зэргээр хариу үйлдэл хийдэг механизм одоогоор тодорхойгүй. Иймд Монгол Улсад зарчим 13-ийн хэрэгжилт хэсэгчлэн нийцсэн гэж үзэж болно. Хэдийгээр хяналт шалгалтын байгууллага өөрийн чиг үүргээ гүйцэтгэн банкнуудыг эрт арга хэмжээ авахыг шаарддаг ч хадгаламжийн даатгагчийн оролцоо нь идэвхтэй бус, мэдээлэл хүлээн авагч төдий байна.

14) Дампуурлыг шийдвэрлэх механизм

Зарчмын агуулга: Банк төлбөрийн чадваргүй болсон нөхцөлд дан ганц татан буулгаж, хадгаламж эзэмшигчдэд шууд нөхөн төлбөр олгохоос гадна илүү зардал багатай, үр нөлөөтэй шийдвэрлэх (resolution) арга хэрэгслүүдийг хэрэглэх боломжтой байх нь системийн тогтвортой байдалд ашигтай. Үүнд: банкны үйл ажиллагааны чухал хэсгүүдийг хадгалах (жишээлбэл, чанартай актив, хадгаламжийг өөр банкинд шилжүүлэх), “түр гүүр банк” байгуулах, банкны өрийг капитал болгон хөрвүүлэх (bail-in) зэрэг олон арга багтана. Ийм өргөн боломжийг олгохын тулд тусгай хууль эрх зүйн орчин шаардлагатай.

Монгол Улсад: 2010-аад оны эхээр банкны салбарт гарсан хүндрэлүүдийг голчлон татан буулгах буюу нэгтгэх аргаар шийдэж ирсэн. Тухайлбал, 2009 онд Анод банк, Зоос банк дампуурахад татан буулгаж, хадгаламж эзэмшигчдэд тодорхой нөхөн төлбөр олгож байсан (албан ёсны хадгаламжийн даатгалын систем бүрдээгүй ч төр оролцсон). 2017 онд Банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж банкныг дахин хөрөнгөжүүлэх, бүтцийн өөрчлөлт хийх талаар зохицуулалтууд оруулсан (жишээ нь, системийн хувьд нөлөө бүхий банкнуудын хувьцааг олон нийтэд гаргах замаар хөрөнгө нэмэх). Гэвч банк төлбөрийн чадваргүй болсон үед гүүр банк байгуулах, албадан нэгтгэх зэрэг нарийн механизмыг одоо ч хуульд нарийвчлан тусгаагүй. ХДК нь бие даан банкны үйл ажиллагааг шийдвэрлэх эрхгүй. Манайд энэ тал дээр уялдаа сул бөгөөд Капитал банкны үед МБ лиценз цуцалсны дараа ХДК нөхөн төлбөр олгох шийдвэрээ гаргасан, түүнээс цаашид шүүхийн дампуурлын үйл явцад төдийлөн оролцохгүй. Олон улсын чиг хандлагаар банкны тусгай шийдвэрлэлийн механизм нэвтрүүлэх нь зүйтэй. ХДБ

нь банк дампуурсан тохиолдолд нөхөн төлбөр олгох аргыг нэвтрүүлсэн ч банкны дампуурлыг бага зардлаар үр дүнтэй шийдвэрлэх дэвшилтэт эрх зүйн орчин бүрдээгүй, ХДК-ийн оролцоо энэ шатанд хязгаарлагдмал байна.

Санал: БтХ, БДМХДтХ зэрэг холбогдох хуулиудад банкинд хувь нийлүүлэгч, өр төлбөрийн эзэд хохирлыг хуваалцах замаар санхүүгийн хүндрэлээс гаргах (bail-in), банкны ашигт ажиллагааг хадгалах гүүр банк байгуулах, хурдан шуурхай актив, өр төлбөрийг шилжүүлэх зэрэг онцгой механизмуудаар банкны татан буугдах ажиллагааг зохион байгуулах боломжийг тусгасан заалтуудыг оруулах шаардлагатай. Ингэснээр зөвхөн татан буулгах ганцхан сонголтоос өөр хувилбаруудыг бий болгож, ХДС-ийн зардал багасах, системд учрах доргилт буурах давуу талтай.

ХДК-ийн шийдвэрлэх ажиллагаанд гүйцэтгэх үүргийг тодорхойлох. Дээрх арга хэмжээнүүдийг хуульд тусгасан тохиолдолд ХДК ямар оролцоотойгоор оролцох талаар хуульд тусгах. Жишээлбэл, “Банк төлбөрийн чадваргүй болсон үед ХДК нь МБ-тай хамтран хамгийн бага зардлын үнэлгээ хийнэ, хадгаламж эзэмшигчдийг бүрэн хамгаалах хувилбар байгаа эсэхийг тооцно” гэх мэт. Мөн шийдвэрлэх арга хэмжээнд даатгалын санг ашиглах нөхцөлийг тодорхой тусгах хэрэгтэй.

15) Хадгаламж эзэмшигчдэд нөхөн төлбөр олгох

Зарчмын агуулга: IADI-ийн шинэчлэгдсэн стандартын дагуу ихэнх хадгаламж эзэмшигчдэдээ 7 ажлын өдөрт багтаан нөхөн төлбөр олгох чадварыг бүх улсууд хөгжүүлэхийг зорьдог. Нөхөн төлбөр олгох үйл явцыг эхлүүлэх талаар хуульд заасан байх шаардлагатай.

Монгол Улсад: БДМХДтХ-д нөхөн төлбөр олгох ажиллагааг эхлүүлэх нөхцөлийг тодорхой заасан. Тодруулбал, банк төлбөрийн чадваргүй болж, тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгох шийдвэр (Монгол банк, эсвэл шүүхээс) гарсан тохиолдолд ХДК нөхөн төлбөр олгоно гэж заасан.

Санал : Урьдчилан төлбөр хийх, хэсэгчлэн төлөх боломж. Хэрэв цаашид томоохон банк дампуурч, нөхөн төлбөрийн ажил удааширвал ХДК хэсэгчлэн төлбөр олгож байх эрх зүйн зохицуулалтыг хуульд тусгах боломжтой (жишээ нь, 7 хоногт багтаан тодорхой бага дүнг төлөөд, үлдсэнийг нь 30 хоногт багтаан гүйцээх гэх мэт). Одоогоор ийм нөхцөл тулгараагүй ч хямралын үед зайлшгүй шаардлагатай тул хуульд тусгаж өгөх нь зүйтэй.

16) Нөхөн олговор, хөрөнгийн эргэн төлөлт

Зарчмын агуулга: ХДС-аас нөхөн төлбөр олгосон тохиолдолд ХДБ нь дампуурсан банкны хөрөнгийн хуваарилалтаас өөрийн төлсөн дүнтэй тэнцэх хэмжээг эргэн төлүүлэх эрхтэй байдаг. Хадгаламжийн даатгагч нь дампуурсан банкны хөрөнгийн хуваарилалтад хадгаламж эзэмшигчийн адил эрхтэй байх ёстой. Ингэснээр даатгалын сан тодорхой хувийг нөхөн нөхөгдөх боломжтой байдаг.

Монгол Улсад: IADI-ийн зарчмаар хадгаламжийн даатгагч нь нөхөн төлбөр олгосны дараа тухайн банкнаас шууд нэхэмжлэл гаргах эрхтэй байх ёстой ч МУ хуульдаа нарийвчлан тусгаагүй.

Санал: БДМХДтХ-д эсвэл Банкны тухай хуульд ХДК нь хадгаламж эзэмшигчдэд нөхөн төлбөр олгосон тохиолдолд, тухайн хадгаламж эзэмшигчийн нэхэмжлэлийн эрхийг олгогч нь болж, банкны төлбөр барагдуулалтын ажиллагаанд тэдний оронд оролцоно. Корпораци нь банк дампуурсан нөхцөлд тухайн банкны хөрөнгийн борлуулалт, активын шилжилтийн явцад тодорхой хэмжээнд хяналт тавих, оролцох эрхийг хууль, дүрмээр олгох. Ингэснээр сангийн эргэн нөхөгдөх хэмжээг нэмэгдүүлэх сонирхлоо хамгаалах боломжтой. Одоо бол ХДК шууд оролцохгүй, МБ хянан гүйцэтгэдэг.

Дээрх шинжилгээнээс харахад Монгол Улсын ХДТ-г IADI-ийн 16 үндсэн зарчимтай харьцуулахад ерөнхийдөө чиг үүргийн зорилго, санхүүжилт, хамрах хүрээ зэрэг суурь элементүүд нь нийцсэн байна. Гэвч системийн цаашид төлөвшиж, олон улсын шинэ шалгуурт хүрэхийн тулд зарим чиглэлээр эрх зүйн шинэчлэл, институцийн чадавх сайжруулалт хэрэгтэй нь тодорхой байна.

Тухайлбал, ХДБ-н засаглалын бие даасан байдлыг бэхжүүлэх, МБ болон ХДК-ийн мэдээлэл солилцоо, хамтын ажиллагааг илүү албан ёсны болгож эрт сэрэмжлүүлэх механизм бий болгох, банкны дампуурлыг шийдвэрлэх тусгай дэглэмийг нэвтрүүлэх зэрэг асуудалд анхаарах шаардлагатай.

Мөн хууль эрх зүйн хүрээнд (албан тушаалтнуудыг хамгаалах эрх зүйн хамгаалалт, буруутай этгээдээс хохирол нэхэмжлэх эрх гэх мэт) шинэчлэл сайжруулалт зайлшгүй шаардлагатай. Эдгээр санал, өөрчлөлтийг үе шаттай хэрэгжүүлснээр Монгол Улсын ХДТ нь IADI-ийн үндсэн зарчмуудыг бүрэн хангаж, цаашид банкны салбарын хувьсамтгай байдал, эрсдэлийг даван туулах чадвар бүхий, хадгаламж эзэмшигчдийн эрхийг бүрэн хэмжээнд хамгаалсан найдвартай систем болох боломжтой юм. Энэ нь

эцсийн дүндээ санхүүгийн зах зээлийн тогтвортой хөгжилд, иргэдийн банкны системд итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд шийдвэрлэх хувь нэмэр оруулна гэж дүгнэж байна.

ДҮГНЭЛТ

МУ-ын Хадгаламжийн Даатгалын Корпораци нь байгуулагдаад удаагүй байгаа хэдий ч Капитал банкны дампуурлын кейс зэрэг бодит сорилтуудад өөрийн үндсэн үүргээ биелүүлж, жижиг хадгаламж эзэмшигчдийн итгэлийг хамгаалж чадсан. Цаашид тус корпорацийн засаглал, бүтэц зохион байгуулалт, хууль эрх зүйн орчныг сайжруулах замаар нэг шат ахиулах цаг ирээд байна. Үүний тулд дээр дурдсанчлан Үндэсний хорооны хараат бус байдлыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны бие даасан байдлыг нэмэгдүүлэх, даатгалын хамрах хүрээ, сангийн менежментийг олон улсын жишигт ойртуулан шинэчлэх шаардлагатай.

БНСУ, Япон зэрэг улсуудын туршлагуудыг харьцуулан үзэхэд хадгаламжийн даатгалын байгууллагын үр нөлөөтэй ажиллах гол нөхцөл нь хүчтэй эрх зүйн мандат, үр дүнтэй засаглалын систем, хангалттай санхүүгийн чадавх, эрсдэлийн удирдлагын чадамж болох нь тодорхой байна. Монгол Улс эдгээр чиглэлд үе шаттай шинэчлэл хийснээр банк санхүүгийн салбарын хувьсамтгай эрсдэлийг даван туулах дархлаатай болж, иргэд, аж ахуйн нэгжүүдийн банкинд итгэх итгэлийг улам бүр бэхжүүлнэ.

Судалгаанаас харахад хадгаламжийн даатгалын тогтолцоо нь зөвхөн хадгаламж эзэмшигчийг хамгаалах үүрэгтэй бус, санхүүгийн тогтвортой байдлыг хангах цогц механизм болон хөгжсөн нь тодорхой байна.

Өмнөд Солонгосын Хадгаламжийн даатгалын корпораци (KDIC) болон Япон улсын Хадгаламжийн даатгалын корпораци (DICJ) нь санхүүгийн хямралын сургамжид тулгуурлан эрх хэмжээ, чиг үүргээ шат дараатайгаар өргөжүүлж, банкны дампуурлаас үүсэх сөрөг нөлөөллийг багасгах, системийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн идэвхтэй оролцоотой байгууллага болон төлөвшсөн байна. Тухайлбал, KDIC нь санхүүгийн байгууллагыг дахин зохион байгуулах, хөрөнгийг шилжүүлэх, гүүр банк байгуулах зэрэг дампуурлын дараах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх эрхтэй бол DICJ нь банкны үйл ажиллагааг тогтворжуулах, дахин хөрөнгөжүүлэх, стратегийн хөрөнгө оруулагч татах замаар санхүүгийн зах зээлийн итгэлийг сэргээхэд чухал үүрэг гүйцэтгэж иржээ.

Хоёр улсын туршлагаас үзэхэд хадгаламжийн даатгалын байгууллагын үр нөлөө нь түүний эрх зүйн орчин, сангийн хангалттай эх үүсвэр, эрсдэлд суурилсан хураамжийн тогтолцоо, мөн төв банк болон санхүүгийн зохицуулагч байгууллагуудтай уялдсан боловч хараат бус шийдвэр гаргах чадвараас шууд хамаарч байна. Ийм бүтэц нь

хадгаламж эзэмшигчдийн итгэлийг хадгалах, банкны системд “bank run” үүсэхээс урьдчилан сэргийлэхэд бодит үр дүн үзүүлдэг болохыг судалгаа нотолж байна.

БНСУ-ын хувьд “Хадгаламж эзэмшигчийг хамгаалах тухай хууль”-ийн 26.2 дугаар зүйлд хадгаламжийн даатгалын сангийн хөрөнгө хүрэлцэхгүй болсон тохиолдолд Хадгаламжийн даатгалын корпораци (KDIC) Засгийн газрын баталгаатайгаар бонд гарган зах зээлээс санхүүжилт татах эрхийг олгосон нь хямралын үеийн онцгой санхүүжилтийн нөөц механизмыг шууд хуульчилсан зохицуулалт болж байна. Мөн бонд гаргахтай холбоотой нөхцөл, хэмжээг урьдчилан тодорхойлж, холбогдох зохицуулагч байгууллагад тайлагнах шаардлага тавьснаар санхүүгийн сахилга бат, ил тод байдлыг хангах эрх зүйн орчныг бүрдүүлсэн нь онцлог юм. Энэ нь банкны системд олон банк нэгэн зэрэг дампуурах нөхцөлд хадгаламжийн даатгалын сангийн хүрэлцээг нэмэгдүүлэх уян хатан боломжийг олгож байна.

Харин Япон улсын хувьд “Хадгаламжийн даатгалын тухай хууль”-д хадгаламжийн даатгалын ердийн сангаас тусдаа, зөвхөн системийн хямралд зориулагдсан хямралын удирдлагын тусгай дансыг хуульчилж, уг дансаар дамжуулан банкны тогтвортой байдлыг хангах санхүүгийн дэмжлэг, дахин хөрөнгөжүүлэлтийг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлсэн байна. Түүнчлэн тус хуулийн 125 дугаар зүйлд Засгийн газраас төсвийн санхүүжилт олгох, 126 дугаар зүйлд Ерөнхий сайд болон Сангийн сайдын зөвшөөрлөөр зээл авах, бонд гаргах эрхийг олгосон нь Япон улсын хадгаламжийн даатгалын тогтолцоог төрийн баталгаатай хамгаалалтын эцсийн механизмаар хангаж өгсөн зохицуулалт юм.

Иймд БНСУ болон Япон Улсын туршлагаас харахад хадгаламжийн даатгалын байгууллагын хямралын үеийн нөөц төлөвлөгөө нь урьдчилан хуримтлуулсан сангаар хязгаарлагдахгүй, харин өрийн хэрэгсэл, төрийн дэмжлэг, тусгай санхүүжилтийн механизмтай уялдсан цогц тогтолцоо байдлаар хуульчлагдсан байна. Эдгээр зохицуулалт нь хадгаламжийн даатгалын байгууллагыг зөвхөн нөхөн төлбөр олгогч бус, харин санхүүгийн тогтвортой байдлыг хангахад идэвхтэй оролцогч институт болгон төлөвшүүлсэн болохыг харуулж байна.

Харин Монгол Улсын хадгаламжийн даатгалын тогтолцоо нь эрх зүйн үндэс суурь бүрдсэн хэдий ч олон улсын хөгжингүй загваруудтай харьцуулахад дампуурлын үеийн оролцоо, дахин зохион байгуулалтын механизм, институцийн бие даасан байдал харьцангуй хязгаарлагдмал хэвээр байна. Иймд Өмнөд Солонгос, Япон улсын туршлагаас дүгнэхэд Монгол Улсад хадгаламжийн даатгалын байгууллагын чиг үүргийг зөвхөн нөхөн төлбөр олгогч бус, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад идэвхтэй

оролцогч институт болгон хөгжүүлэх бодит хэрэгцээ байгааг энэхүү судалгаа харуулж байна.

Тиймээс Монгол Улсын банкны салбарын эрсдэлийн удирдлага, хадгаламж эзэмшигчдийн хамгаалалт, олон нийтийн итгэлцэл цаашид илүү тогтвортой, үр ашигтай түвшинд хүрэх боломжтой гэж дүгнэж байна.

САНАЛ

Дээрх дүн шинжилгээ, олон улсын харьцуулсан туршлагад үндэслэн Монгол Улсын хадгаламжийн даатгалын системийг бэхжүүлэх, МХДК-ийн засаглал, бие даасан байдал, эрсдэлийн удирдлага, хадгаламж эзэмшигчийн хамгаалалтыг сайжруулах чиглэлээр дараах нарийвчилсан зөвлөмжүүдийг дэвшүүлж байна :

1. МХДК-ийн засаглал, удирдлагын шинэчлэл: IADI-ийн зөвлөмжид бусад санхүүгийн аюулгүйн сүлжээний төлөөлөл (төв банк, засгийн газар гэх мэт) нь удирдах зөвлөлийн тэргүүнээр давхар алба хаахгүй байх нь зохимжтой гэж үздэг (International Association of Deposit Insurers, CORE PRINCIPLES FOR EFFECTIVE ISLAMIC, 2021). Хадгаламжийн даатгагчийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн нь ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэхүйц байх ба бусад санхүүгийн аюулгүйн сүлжээний төлөөлөл олонхыг бүрдүүлдэггүй, тэдгээр нь зөвлөлийн даргаар томилогддоггүй байх. Хадгаламжийн даатгалын Үндэсний хорооны бүрэлдэхүүн, томилгооны зарчмыг өөрчилж, илүү хараат бус, мэргэжлийн баг болгох.
2. Тухайлбал, Үндэсний хорооны даргыг Төв банкнаас тусад нь хараат бус гишүүн эсвэл МХДК-ийн өөрийн гүйцэтгэх захирал байхаар хуульчилна. Мөн хорооны гишүүдийн тал буюу түүнээс илүү хэсгийг банк санхүү, эрх зүйн өндөр туршлагатай хөндлөнгийн гишүүдээр бүрдүүлэх (тоо, квотыг хуульд зааж өгсөн ч болно). Төрийн албан тушаалтнуудын оролцоог стратегийн чиглэлд санал зөвлөгөө өгөх түвшинд байлгаж, өдөр тутмын шийдвэрт шууд оролцохгүй байх чиглэл рүү явуулах. Ингэснээр МХДК нь аливаа улс төрийн нөлөөллөөс ангид, зөвхөн хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг дээдэлсэн мэргэжлийн байгууллага болон төлөвшинө.
 1. Үйл ажиллагааны бие даасан байдал, хамтын ажиллагаа: МБ, СЗХ-ны хооронд санхүүгийн мэдээлэл солилцооны протокол байгуулах, үүнийг хуульчилсан байдлаар баталгаажуулах. Энэ хүрээнд МХДК нь банкнуудын төлбөр чадвар, активын чанарын талаарх шинэчлэгдсэн мэдээллийг тогтмол (жишээ нь улирал тутам) авч, өөрийн эрсдэлийн үнэлгээ гаргаж байх нь зүйтэй. Мөн Сангийн яам, Монгол банктай хамтран санхүүгийн хямралын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний “гарын авлага” (playbook) боловсруулж, МХДК-ийн үүрэг ролийг тодорхой зааглаж өгөх шаардлагатай. Энэ нь гэнэтийн нөхцөлд байгууллага хоорондын уялдаа, тус тусын бие даасан шийдвэр гаргах хүрээг ойлгомжтой болгож өгнө. Түүнчлэн МХДК-д яаралтай нөхцөлд хэрэгжүүлэх хөрвөх чадварын

дэмжлэгийг өмнө нь тохирсон зээлийн шугамаар авах эрхийг нь тодорхой болгох (жишээ нь, МБ-аас тодорхой хэмжээнд репо зээл эсвэл Засгийн газрын баталгаатай бонд гаргах замаар санхүүжилт олгохоор урьдчилан гэрээ байгуулах). Энэ мэт санхүүжилтийн бэлтгэл механизмыг урьдчилан тохирч хуульчлах нь хямралын үед итгэлцлийг нэмэгдүүлж, МХДК-ийн бие даан ажиллах чадамжийг өсгөнө.

2. Эрсдэлийн удирдлага, хяналтын чадавхыг нэмэгдүүлэх: МХДК-ийн дотоод бүтцэдээ эрсдэлийн шинжилгээ, мониторингийн нэгж байгуулж, хүний нөөцийг чадавхжуулах хэрэгтэй. Энэ нэгж нь МБ-аас авсан мэдээлэл болон олон нийтийн санхүүгийн үзүүлэлтүүдэд үндэслэн банк бүрийн эрсдэлийн оноо, даатгалын сангийн шаардагдах хөрөнгийн төсөөлөл зэргийг байнга тооцдог байх нь зүйтэй. Эрсдэлийн суурь хураамжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, адилтгах үнэлгээгээр нь ангилж, тохирох шимтгэлийн хувийг тогтоодог болоход шаардлагатай эрх зүйн акт, техникийн арга хэмжээг авах. Энэ нь эрсдэлтэй үйл ажиллагаа явуулж буй банкнуудад санхүүгийн дарамт бий болгон сахилга бат төлөвшүүлэх давуу талтай. Өндөр эрсдэлтэй банк өндөр шимтгэл төлөх нь шударга ёсны асуудал төдийгүй урьдчилан сэргийлэх дохио болдог.
3. Даатгалын хамгаалалтын өргөтгөл, иргэдийн итгэлийг бэхжүүлэх: Даатгалын нөхөн төлбөрийн дээд хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэхээр шийдвэрлэж, тухай бүрд нь олон нийтэд мэдээлэн, хадгаламж эзэмшигчдийн итгэлийг нэмэгдүүлэх. Жишээлбэл, Хадгаламжийн даатгалын дээд хэмжээг 20 сая бус бодит эдийн засгийн хэмжүүр, инфляцийн түвшинтэй уялдуулан 5 жил тутамд нэг удаа дахин хянан тогтоож байх механизмыг хууль, дүрэмд тусгах. Мөн жижиг, дунд бизнес эрхлэгчдийн банкинд байршуулсан гүйлгээний дансны үлдэгдлийг хамгаалах талаар анхаарах (зарим улс оронд ААН-ийн цалингийн сан зэрэг гүйлгээний зориулалттай дансыг хамгаалдаг онцлогтой). Манайд төрийн болон НДШ, ЭМД-ын сангийн мөнгө даатгалд хамрагдахгүй байгаа нь зөв зүйтэй ч, хувийн хэвшлийн хөдөлмөрийн хамт олон, бизнесийн эргэлтийн хөрөнгийн хэсэг болсон хадгаламжийг хамгаалах нь эдийн засгийн тогтвортой байдалд тустай. Үүнийг шийдэх нэг хувилбар нь дээр дурдсан дээд хэмжээг нэмэгдүүлснээр их хэмжээний хадгаламжтай ААН-үүдийн мөнгө хамрагдах явдал юм.

4. Хямралын үеийн нөөц төлөвлөгөөтэй байх, практикт турших: Хямралын үеийн онцгой санхүүжилтийн механизмыг хуульчлах Монгол Улсын “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль”-д хадгаламжийн даатгалын сангийн хөрөнгө хүрэлцэхгүй болсон тохиолдолд бонд гаргах, өрийн хэрэгсэл ашиглан зах зээлээс санхүүжилт татах эрхийг БНСУ-ын жишгийн адил тодорхой заалтаар тусгах шаардлагатай.
5. Системийн хямралд зориулсан тусгай сан, дансны зохицуулалтыг бий болгох
Япон улсын туршлагыг үндэслэн хадгаламжийн даатгалын ердийн сангаас тусдаа, зөвхөн санхүүгийн системийн хямралд зориулагдсан тусгай данс буюу сангийн эрх зүйн зохицуулалтыг нэвтрүүлэх нь хямралын үед үндсэн даатгалын үүргийг алдагдуулахгүй байх нөхцөлийг бүрдүүлнэ.
6. Төрийн дэмжлэгийн “эцсийн баталгаа”-г тодорхой болгох
Хадгаламжийн даатгалын сан болон хураамжийн орлого хүрэлцэхгүй болсон нөхцөлд Засгийн газраас санхүүгийн дэмжлэг үзүүлэх боломж, нөхцөлийг Япон улсын адил хуульд тодорхой тусгаснаар олон нийтийн итгэлийг хадгалах бодлогын баталгаа бүрдэнэ.
7. Хадгаламжийн даатгалын байгууллагын институцийн үүргийг өргөжүүлэх
Дээрх орнуудын жишгээс харахад хадгаламжийн даатгалын корпораци нь зөвхөн нөхөн төлбөр олгогч бус, банкны салбарын тогтвортой байдлыг хангахад идэвхтэй оролцогч институц байдлаар төлөвшсөн байна. Иймд Монгол Улсад ч хадгаламжийн даатгалын байгууллагын чиг үүргийг хямралын удирдлага, банкны дахин зохион байгуулалттай уялдуулан үе шаттайгаар өргөжүүлэх нь зүйтэй.
8. Олон нийтийн мэдээлэл, итгэлцлийг нэмэгдүүлэх: МХДК нь өөрийн үйл ажиллагааны ил тод байдлыг дээшлүүлж, иргэд олон нийтэд хадгаламжийн даатгалын ач холбогдол, хязгаарлалтын талаар тогтмол мэдээлэл өгч байх ёстой. Хуулийн 15.7-д энэ чиглэлээр мэдээллийн агуулга, түгээх журмыг Үндэсний хороо батална гэж заасан байдаг ч, бодит байдалд олон нийт төдийлөн мэдээлэлтэй бус байна. Тиймээс МХДК нь жил бүр санхүүгийн боловсролын төлөвлөгөө гарган, банкнуудтай хамтран хадгаламж эзэмшигчдэд зориулсан ойлгомжтой гарын авлага, вэбсайт, аппликейшн зэргээр дамжуулан мэдээлэл түгээх. Олон улсад хадгаламжийн даатгагчид

жил бүр олон нийтийн судалгаа хийж, өөрийн мэдлэг, ойлголтын түвшинг үнэлдэг практик бий. МХДК ч энэ аргыг нэвтрүүлж, ямар мэдээллийг иргэдэд хүргэх шаардлагатайгаа тодорхойлж байх нь зүйтэй.

9. Эрт үеийн оролцооны эрх зүйн баталгааг сайжруулах: ХДК нь БДМХДтХ-д “эрт илрүүлэлт, цаг үеийн оролцоо”-ны нэг хэсэг гэж заасан ч энэ нь ерөнхий зохицуулалтаар хязгаарлагдаж байна. Иймд ХДК болон МБ хоорондын мэдээлэл солилцоо, хамтын ажиллагааны механизмыг хуульчлах нь зүйтэй. Тухайлбал, банкны зохистой харьцааны үзүүлэлтүүд тодорхой түвшинд хүрсэн тохиолдолд ХДК-д албан ёсоор мэдэгдэх, эсвэл ХДК-ийн төлөөллийг Монгол банкны хяналт шалгалтын хорооны зарим хуралдаанд оролцуулах зэрэг зохицуулалтыг тусгаж болно. IADI-ын Суурь зарчмын 13-д заасанчлан, хадгаламжийн даатгагч нь тогтолцооны салшгүй нэг хэсэг болохын тулд санхүүгийн аюулгүйн сүлжээний оролцогчдын хооронд мэдээлэл, арга хэмжээний уялдаа хууль, дүрмийн хүрээнд тодорхой байх ёстой. Үүнийг хангах үүднээс Монгол банк, ХДК, СЗХ зэрэг байгууллагуудын хооронд байгуулсан санамж бичиг, журам зэргийг эрх зүйн хувьд баталгаажуулах шаардлагатай. Мөн ХДК-д шаардлагатай тохиолдолд гишүүн банкнуудаас тодорхой мэдээлэл (жишээ нь хадгаламж эзэмшигчдийн бүтэц, дансны төлөв, банкны активын чанарын тайлан гэх мэт) шууд авах эрх олгохыг ч авч үзэж болно. Энэ нь банк дампуурахад нөхөн төлбөр олгох системийг боловсронгуй болгох, банкны дампуурлаас урьдчилан сэргийлэхэд туслах юм.
10. ХДК-ийн шийдвэрлэх ажиллагаанд оролцох үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх: Одоогийн байдлаар банк татан буугдмагц Монгол банк эрх хүлээн авагч томилж, тус эрх хүлээн авагч нь хөрөнгийг борлуулах, өр төлбөрийг барагдуулах үүргийг хүлээнэ. ХДК зөвхөн нөхөн төлбөр төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх санхүүжилтийг гаргаад, цаашдын ажиллагаанд идэвхтэй оролцдоггүй. Харин Япон, Солонгос улсад хадгаламжийн даатгагчийг дампуурсан банкны хөрөнгийн хууль ёсны хүлээн авагч, шингээгч (liquidator/receiver) болгон оролцуулдаг жишиг бий. АНУ-ын FDIC, БНСУ-ын KDIC зэрэг нь дампуурсан банкны эрх хүлээн авагчаар томилогдон, шууд удирдлагаар хангадаг. Энэ нь даатгалын сангийн төлбөрийг буцаан олж авах, хөрөнгийг үр ашигтай удирдах, шийдвэрлэлт удаашрахгүй байх давуу талтай. Монгол Улсын БДМХДтХ-д

ийм зохицуулалт одоогоор байхгүй тул Банкны тухай хууль болон холбогдох журмуудад нэмэлт оруулж, ХДК-ийг төлбөр төлөгдөх үеийн гол оролцогчдын нэг (хамтран эрх хүлээн авагч эсвэл хяналтын зөвлөлийн гишүүн гэх мэт) болгох боломжтой. Ингэснээр ХДК нь даатгалын сангийн ашиг сонирхлыг төлөөлөн банкны дампуурлын үйл явцыг хянах юм.

11. “Loss minimizer” түвшний зарим бүрэн эрхийг олгох (онцгой нөхцөлд):

Монголын санхүүгийн системд системийн нөлөө бүхий хэд хэдэн банкнууд байдаг (Хаан банк, Худалдаа хөгжлийн банк зэрэг). Хэрэв системийн нөлөө бүхий банкинд хүндрэл үүсэхэд зөвхөн 20 сая төгрөг хүртэлх хадгаламжийг хамгаалаад зогсох нь санхүүгийн тогтвортой байдлын хувьд хангалтгүй байх эрсдэлтэй. Иймд БНСУ-ын жишгээр, онцгой нөхцөлд (systemic risk exception) хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг бүрэн хамгаалах, банкны үйл ажиллагааг тасралтгүй хадгалах зорилгоор Засгийн газар болон Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн шийдвэрээр даатгалын санг зорилтот байдлаар ашиглах боломжийг эрх зүйн хувьд бүрдүүлэхийг санал болгож байна. Тухайлбал, системийн хувьд нөлөө бүхий банк дампуурахад төлбөр барагдуулах дарааллаар ажиллавал олон иргэн, ААН хохирох, сөрөн зогсох хор нөлөө ихтэй гэж үзвэл ХДК нь тухайн банкны даатгагдаагүй хадгаламжид хүртэл түр хамгаалалт санал болгож болно. Үүнийг хийхдээ заавал бүх хадгаламжийг татвар төлөгчдийн мөнгөөр аврах бус, харин банк хооронд нэгтгэх боломжтой. БНСУ-д системийн нөлөө бүхий банкны хувьд нэгтгэх, дахин хөрөнгөжүүлэх гарцуудыг илүүд үзэж, KDIC санхүүгийн дэмжлэг олгодог туршлага байна. Монгол Улсад ч энэ төрлийн уян хатан зохицуулалтыг хуульд тусгаж өгвөл ирээдүйд үүсэж болзошгүй санхүүгийн хямралын үед хурдан, уян хатан шийдвэр гаргах боломж бүрдэх юм. Гэхдээ ийм эрх мэдлийг урвуулан ашиглахгүй байх, ёс бус дэмжлэг болж хувирах эрсдэлийг хаахын тулд заавал олонхын шийдвэр (Жишээ нь, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн дийлэнх олонх гишүүний дэмжлэгээр) гаргах, зөвхөн системийн хор нөлөөтэй гэж хараат бус шинжээчид дүгнэсэн тохиолдолд хэрэглэх зэрэг заалтуудыг хуульд давхар тусгах нь зүйтэй.

12. Тусгай зориулалтын банк байгуулах, хэрэгжүүлэх зохицуулалтыг тодорхой болгох: БДМХДтХ-д “тусгай зориулалтын банк” байгуулах үеийн

санхүүгийн дэмжлэгийн талаар дурдсан хэдий ч ямар журмаар, хэрхэн байгуулах, удирдлагаар хэрхэн хангах зэргийг тусгайлан заагаагүй, нарийвчлан тусгагдаагүй байна. Үүнийг Банкны тухай хууль буюу төв банкны эрх зүйн актуудад нарийвчлан журамлах шаардлагатай. Тухайлбал, хэрэв ямар нэг банк дампуурахад хөрөнгийг нь шинэ байгууллага (түр гүүр банк) руу түр шилжүүлэн харилцагчдыг хамгаалах бол энэ гүүр банкиг Монгол банк эсвэл Засгийн газар шийдвэр гарган байгуулж, дүрмийн сангийн эх үүсвэрийг нь ХДК-ийн сангаас бүрдүүлэх, үйл ажиллагааг нь тодорхой хугацаанд (жишээ нь 1 жил) тогтвортой явуулах нөхцөлийг МБ хариуцах зэргийг журамлах хэрэгтэй. Одоогоор дээрх аргыг хэрэглэсэн туршлага байхгүй ч хуулийн орчныг бүрдүүлж өгснөөр хэрэгцээ гарвал цаг алдалгүй ашиглах боломжтой болно. IADI-ын зарчимд онцолсончлон, үр дүнтэй эрх зүйн орчин бүрэлдсэн байх нэг шинж нь түр хугацааны банк байгуулах, хөрөнгө өрийг шилжүүлэх зэрэг өргөн арга хэрэгсэл хуульд нарийвчлан тусгагдсан байх явдал юм.

13. Хууль, зохицуулалтын давхардал, хийдлийг арилгах: Эцэст нь, хадгаламжийн даатгалтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгүүдийн уялдаа, нийцлийг тогтмол хянаж сайжруулах шаардлагатай. Тухайлбал, МБ-аас 2019 онд баталсан “Банкийг албадан татан буулгах арга хэмжээг хэрэгжүүлэх журам” нь (Ерөнхийлөгчийн тушаал А-96) татан буулгах үеийн дэг, дарааллыг тогтоосон байдаг. Үүнд ХДК-ийн оролцоог хэрхэн хангах, мэдээлэл солилцооны нарийвчилсан зохицуулалт зэргийг тусгасан эсэхийг дахин нягтлан, шаардлагатай бол нэмэлт өөрчлөлт оруулах нь зүйтэй. Мөн даатгалын сангийн хөрөнгийг өөр зорилгоор ашиглахыг хориглох, хамгаалах заалтыг чанд мөрдөх хэрэгтэй. Саяхан (2025 оны 3 сард) Засгийн газраас ХДК-ийн валютын нөөцийн хөрөнгийг Монгол банк руу шилжүүлэн төв банкны валютын нөөцөд бүртгэх шийдвэр гаргасан нь даатгалын сангийн бие даасан байдалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй тул цаашид анхаарч, зохицуулалт хийх шаардлагатайг харуулж байна. ХДК нь ямар ч нөхцөлд өөрийн сангийн хөрөнгийг зөвхөн хадгаламж эзэмшигчдийг хамгаалах чиг зорилгод зарцуулах ёстой бөгөөд бусад санхүүгийн бодлогын арга хэрэгсэл болгон ашиглах нь зүйд нийцэхгүй юм.

Дээрх зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх нь МХДК болон Монгол Улсын банк, санхүүгийн тогтолцоонд олон талын эерэг өөрчлөлт авчирна. Нэгдүгээрт, хадгаламжийн даатгалын

байгууллага илүү бие даасан, чадварлаг болж, аливаа шийдвэр гаргахдаа улс төр, салбарын дарамт шахалтаас ангид, мэргэжлийн үндэслэлтэй хандах боломж бүрдэнэ. Хоёрдугаарт, хяналт шалгалт, эрсдэлийн удирдлагын механизм сайжирснаар банкны салбарт эрт сэрэмжлүүлэх дохиолол ажиллаж, ноцтой хүндрэл үүсэхээс өмнө арга хэмжээ авах нөхцөл сайжрах юм. Гуравдугаарт, хууль эрх зүйн орчин сайжирснаар банк дампуурсан тохиолдолд зөвхөн жижиг хадгаламж эзэмшигч төдийгүй тодорхой хэмжээнд бизнесийн харилцагчдын итгэл хамгаалагдаж, ингэснээр санхүүгийн системийн тогтвортой байдал бэхэжнэ. Дөрөвдүгээрт, олон улсын сайн туршлагыг нутагшуулснаар Монголын хадгаламжийн даатгалын систем Олон улсын хадгаламжийн даатгагчдын холбоо (IADI)-ын Суурь зарчмуудтай илүү нийцэж, цаашид гадаад орчинд итгэл хүлээх түвшинд хүрэх боломжтой.

НОМ ЗҮЙ

Монгол хэл дээрх:

1. Банкин дахь мөнгөн хадгаламжийн тухай хууль. (2013).
2. Болдбаатар, А (2023). Капитал банкийг татан буулгах шийдвэр гаргалаа. *Ikon.mn*.
3. Монгол банк. (2019). Банкны салбарын хууль тогтоомжийн эмхэтгэл.
4. Монгол банк. (2020). *Даатгалын ач холбогдол*.
5. Монголбанк. (2019). Капитал банкийг татан буулгах шийдвэр гаргалаа.
6. Монголбанк. (2025). *Монгол улсын төв банк*.
7. Монгол өмгөөлөгч. (2014). *Монгол өмгөөлөгч хууль зүйн фирм*
8. Өнөржаргал, М (2019). Д.Дамба-Очир: Байдлыг улам дордуулахгүйн тулд "Капитал"-ын дампуурлыг зарласан. *Sonin.mn*.
9. DICOM. (2025). *Deposit Insurance Corporation Of Mongolia*. <https://dicom.mn>
10. Opendata lab Mongolia . (2022).
11. Opendata lab Mongolia. (2025).

Гадаад хэл дээрх:

1. Bank for International Settlements . (2024 оны 05 13). Bank for International Settlements.
2. Bank for International Settlements ;. (2024). Basel Committee membership.
3. Benston, G. J, & Kaufman, G. G. (1997). FDICIA after five years. *Journal of economics*.
4. Calomiris, C. W., & Jaremski, M. (2019). Stealing deposits: Deposit insurance, risk-taking, and the roots of banking crises. *Journal of Financial Economics*.
5. David Walker. (2018). *Americas Deposit Insurance Forum* . International Association of Deposit Insurers.
6. Demirgüç-Kunt, A., Kane, E. J., & Laeven, L. (2008). Deposit Insurance Around the World: Issues of Design and Implementation. *MIT Press*.
7. Deposit Insurance Act of Korea. (1995).
8. Deposit Insurance of Vietnam. (2023). Resolving weak credit institutions - International experience and relations to Vietnam.
9. *DEUTSCHE BUNDESBANK EUROSISTEM*. (2025). <https://www.bundesbank.de/en>
10. Diamond, D.W. . (1984). Financial intermediation and delegated monitoring . *The Review of Economic studies*.

11. Diamond, D.W., & Dybvig, P. H. (1983). Bank runs, deposit insurance, and liquidity . *Journal of Political Economy* .
12. Douglas W. Diamond, & Philip H. Dybvig. (1986). Banking Theory, Deposit Insurance, and Bank Regulation. *The Journal of Business*.
13. Financial Stability Board. (2012). FSB completes Thematic Review on Deposit Insurance Systems.
14. Financial Stability Institute. (2022). Core Principles for Effective Deposit Insurance Systems – Executive Summary.
15. Greene Mark Richard. (2025 оны 04 14). Britannica.
16. IADI. (2009). Core Principles for Effective Deposit Insurance Systems.
17. IAN S. McCarthy. (огноо байхгүй). Deposit Insurance : theory and practice. *Deposit insurance corporation*.
18. Insurers, I. A. (2025). IADI.
19. International Association of Deposit Insurers. (2020). *Public Policy Objectives for Switzerland*.
20. International Association of Deposit Insurers. (2021). *CORE PRINCIPLES FOR EFFECTIVE ISLAMIC*.
21. Kane, E. J. (1990). Principal-agent problems in S&L salvage. *Journal of Finance*.
22. Monetary and Capital Markets department. (2024). *Japan financial sector assessment program*. Washington, D.C: International Monetary Fund .
23. Patrizia Baudino, Carlos Sánchez and Ruth Walter. (2021). *Institutional arrangements*. Bank for international settlements.
24. Science Direct. (2014). Deposit Insurance.
25. Struckmann, J. (2021). Reforms of the German voluntary deposit protection scheme on the horizon.